

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2023 ОНЫ 03 ДУГААР САРД  
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

Сайншанд

/2023.03.14/ Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 6 дугаар хуралдааныг 71 хувийн ирцтэйгээр зохион байгуулж хуралдаанаар аймгийн ИТХ-ын ээлжит 11 дүгээр хуралдааны тов тогтоох тухай, мөн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

/2023.03.14/ Олон улсын чанарын менежментийн тогтолцооны талаар ойлголт өгөх сургалтад аймгийн ИТХ-ын ажлын албаны албан хаагчид хамрагдсан. Сургалтыг Тэргүүлэх аудитор, ерөнхий зөвлөх, сургагч багш Т.Бадамсэд, сургалтын Дорноговь аймгийн хариуцсан менежер Ангарагнаран нар зохион байгуулж мэдээлэл хүргэсэн.

/2023.03.22/ Аймгийн ИТХ-ын ээлжит 11 дүгээр хуралдааныг зохион байгуулж хуралдаанаар 14 асуудал хэлэлцэн 15 шийдвэрийг батлан гаргасан.

1. “Нээлттэй Дорноговь аймаг” зорилтот хөтөлбөр батлах тухай
2. Дорноговь аймгийн “Аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөө” батлах тухай
3. Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө-2” үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтэд санал авах тухай
5. Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын төвд “Халзан-Уул” рашаан сувиллыг нэгтгэсэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг шинэчлэн батлах тухай
6. Сонгуулийн хороо байгуулах тухай
7. АИТХ-ын төлөөлөгчийг хороонд хуваарилах тухай
8. АИТХ-ын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай
9. ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай
10. Аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээллийг сонсох
11. Бусад /4 асуудал/

**Аймгийн ИТХ-ын даргын шагнал**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр 2, “Өргөмжлөл”-өөр 22 нийт 24 иргэнийг шагнаж урамшуулсан байна.

**Аймгийн ИТХ-ын даргын захирамж**

Аймгийн ИТХ-ын даргын нийт 18 захирамж гарснаас ангилбал Буцалтгүй тусламж олгох тухай-1, Хүндэтгэл үзүүлэх тухай-4, Шагнах тухай-4, Дэмжлэг үзүүлэх тухай-3, Ээлжит хуралдааны тов зарлах тухай-1, Бусад асуудлаар-5 захирамж гарсан байна.

## **Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын нийт 6 тушаал гарснаас Хөрөнгө зарцуулах тухай-2, Буцалтгүй тусламж үзүүлэх тухай-2, бусад асуудлаар 2 шийдвэр гарсан байна.

### **ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС 2023 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

#### **НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

##### **Дотоод ажил:**

Аймгийн Засаг даргын Захирамж А 78, Захирамж Б 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 19, Тушаал Б 45 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 78 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 296 албан бичиг ирснээс 24 нь хугацаатай албан бичиг ирж хугацаанд шийдвэрлэсэн. Байгууллагаас 118 албан бичиг бусад байгууллага, иргэнд хүргүүлсэн байна.

##### **Өргөдөл, гомдол, шагнал:**

Аймгийн Засаг дарга Тамгын газарт хандаж нийт 178 өргөдөл, гомдол ирснээс:

- Бичгээр -70,
- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – **99**,
- АЗДТГ-ын иргэдийн санал хүсэлт хүлээн авах **7052-11-11** утсаар-5, <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар – 4 ирсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 24 өргөдөлд хариуг өгч, 36 өргөдөл судлагдаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 35 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын:

- 133 нь буюу 74,7 хувь нь санал, хүсэлт,
- 41 нь буюу 23.0 хувь нь гомдол,
- 4 нь буюу 2,2 хувь нь талархал байв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдол, саналын 72 хувийг хугацаанд нь шийдвэрлэж, 17 хувь нь хугацаа болоогүй, 11хувь нь хугацаа хоцорч байна.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 35 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч, 30 иргэний шагналын материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв. Эдгээр нь:

Монгол улсын гавъяат зүтгэлтэн цолоор – 1,

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор – 2,

Алтан гадас одонгоор – 17,

Хөдөлмөрийн хүндэт медалиар – 15, иргэнийг шагнуулахаар уламжилсан байна.

2023 онд "Алдарт эх" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах эхчүүдийн тодорхойлолт материалыг хүлээн авч нэгтгэж байна.

Аймгийн Засаг даргын Засаг даргын "Жуух"-аар 16 иргэний, "Өргөмжлөл"-өөр 42 иргэний материалыг хүлээн авч бүртгэн, Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн байна.

### **Мэдээллийн технологийн чиглэлээр:**

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 77 мэдээг албан ёсны цахим хуудас болон сайтад байршуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 6 байгууллагын 12 албан хаагчид өгч ажилласан.

### **ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:**

#### **СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН, ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ:**

-Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 09:00 цагаас 03 дугаар сарын 03-ны өдрийн 09:00 цагийн хооронд хийж, шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс улсын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд тус өдрүүдэд шалгалтын бүрэлдэхүүнд хэлтсийн дарга Ч.Нандин-Эрдэнэ ажиллав.

1. Дорноговь аймгийн хэмжээнд "Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар жил бүр чиглэл хүрүүлэн тус өдрийн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа зохион байгуулж хэвшсэн. Аймгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнд нийт 1400 гаруй иргэн, 100 гаруй аж ахуй, нэгж байгууллага оролцсон бөгөөд цахим хэлбэрээр 60,000 гаруй иргэд хандсан хандалттай байна. Орон нутгийн хэмжээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.
2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгсөн зөвлөмжийн дагуу Хурдан морины үсэргээ, сунгаа наадмыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг хориглосон чиглэлийг албан бичгээр сумдын засаг дарга нарт хүргүүлсэн.

3. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 7 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг илгээж ажилласан.

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Авлигатай тэмцэх газраас санал
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.3.1. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор сум, төрийн байгууллагын дунд нэг сарын хугацаатай “Дэвжээ-2023” арга хэмжээг зохион байгуулах	- Бүх сум болон холбогдох төрийн байгууллагууд хамрагдаж, сум бүрд тодорхой ажлыг зохион байгуулсан байна.	Тухайн төрийн байгууллага, сумдын онцлогт тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр чиглэл өгөх /ганц Дэвжээ арга хэмжээгээр хязгаарлагдахгүй/
		5.3.2. төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн, сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	-зөвлөгөөний тоо-1 -оролцогчдын тоо-300  Мэдээллээр хангагдаж авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна.	Нэгдсэн сургалт, зөвлөгөөний үр дүн, үр нөлөөг сайтар анхаарах.  Үүнээс илүүтэйгээр төрийн байгууллага бүр, төрийн албан хаагч бүр 1 үйлдэл, оновчтой санаа гаргаж ажиллах тал дээр анхаарах
		5.3.3. Орон нутаг дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, сумдад ажиллах	Сумдад ажиллаж, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн байна. Зөрчил дутагдлыг арилгах, мэдээлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих нь Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг.  Төрийн албан хаагчдад авлигыг мэдээлэх үүргийг сурталчлах /Авлигын эсрэг хуулийн 8.1/
		5.3.4. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 хүртэлх сая төгрөгийн төслийн	Төрийн бус байгууллагыг татан оролцуулсан	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай

	уралдаан зарлах	байна. Төслийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо 1000-2000 хүн байна.	хуулийг иргэд, олон нийтэд сурталчлах
	5.3.5. Захиргааны байгууллагын нэхэмжлэлтэй хэрэг шийдвэрлэлтэд анхаарах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг хуулийн хугацаанд ШШГГ-т өгч төрд учирсан хохирлыг барагдуулах талаар сум бүрд албан чиглэл өгөх	сумдад чиглэл өгч энэ төрлийн зөрчлийг таслан зогсоосон байна.	Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгох үйл ажиллагааг зохих журмын дагуу хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах /АТГ дээр гомдол, мэдээлэл ирдэг/
	5.3.6. Уул, уурхай, хил, гааль, зам тээврийн салбарт /тээвэрчид, компани, аж ахуй нэгж байгууллага, иргэд/-д авлига, ашиг сонирхол үүсгэхгүй байхад анхаарч уулзалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Зорилтод бүлгийг тодорхойлон үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	Иргэд, ах ахуй нэгжийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, тэднээс гарсан саналуудыг холбогдох байгууллагуудад тогтмол хүргүүлэх /Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг АТГ-т тухай бүрд мэдээлэх /
	5.3.7. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран орон нутаг дахь авлигын эсрэг үйл ажиллагаа, нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээ хийж, тодорхой арга хэмжээ зохион байгуулсан байна.	Худалдан авалт, төсвийн хөрөнгийн сахилга баттай холбоотой асуудал дээр анхаарч ажилламаар байна.

4. Нууцлалаа шалгаж, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье.  
[#яг](#) одоо нууц үгээ сольцгооё цахим нөлөөллийн постер бэлтгэн хууль, эрх зүйн хэлтэс цахим хуудсаар дамжуулан 119 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.
5. Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа. Аймгийн засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ны

өдрийн а/222 дугаар захирамжаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж Монгол Улсын хилийн тухай хууль, Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг гишүүдэд даалгалаа

6. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог яаралтай хуралдуулах санал гаргаж бага насны хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хэрэг хорооны гишүүдийг зүгээс анхаарах, хорооны ажлын алба холбогдох байгууллагад хүүхдийн нууцлалыг хадгалах талаар чиглэл өгч ажилласан. Мөн хохирсон байж болзошгүй иргэдийг хүлээн авч уулзаж хамгаалах байран зуучлан үйлчилгээ үзүүлэв. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах нөлөөллийн аяныг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөв.
7. Монгол Улсын засгийн газрын 11.11 төвөөс ирүүлсэн өргөдөл гомдолд холбогдох ажиллагааг явуулж иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Замын-Үүд сум дахь Хилийн цэргийн 0108 дугаар анги, Гааль, Боомтын, Авто тээврийн үндэсний төв, цагдаагийн хэлтэст чиглэл хүргүүлэн гомдол гаргагч нартай утсаар холбогдож гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэв.
8. Шүүх хурлыг хойшлуулах тухай 2 удаагийн хүсэлт бичиж, нэг хэргийн материалтай танилцаж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон. Мөн зарим хэрэгт өмгөөллийн үйлчилгээ авах талаар саналыг танилцуулан холбогдох материалыг гарган өгсөн.
9. Архивын ерөнхий газрын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 3 дугаар сард мэргэжил олгох сургалтад 6 төрийн сургалтад байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан хамрагдав.
10. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцсан. Орон нутгийн хувьд тус хуулиар хүн ам, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог хангах тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж, зарим зүйл, заалтыг бусад хуульд тусгах талаар дараах саналыг Монгол Улсын уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт хүргүүлэв. Тус хуулийн төсөлд санал ирүүлэх тухай албан бичгийг сумдад хүргэж, зарим сумдаас холбогдсон иргэдийн саналыг утсаар авч төсөлд тусгав.
11. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тус байгууллагын удирдлага зохион байгуулалт, дотоод ажил, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, төсөв санхүү, чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 14-29-ны хооронд Ч.Нандин-Эрдэнэ (Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга), У.Шинэчимэг (Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн), Н.Баттуяа (Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга), Х.Анхчимэг (Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий санхүүч, Х.Мягмарсүрэн (Аймгийн

ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн) нарийн бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Шалгалтаар чиг үүргийн хэрэгжилт, зохион байгуулалт, төсөв санхүү, төрийн албаны ёс зүй, зэрэг байдалд хяналт шалгалт явуулж, шаардлагатай тохиолдолд ажилтан, албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээлэл авах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулах, баримт материалыг хуулбарлан авах, санал асуулга авах хэлбэрээр зохион байгуулж илтгэх хуудсыг боловсруулсан.

12. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу томилохоор нэр дэвшүүлсэн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар хүргүүлсэн.
13. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, постер, шторкийг бэлтгэн 2023 оны 04 дүгээр сард нийтэд түгээх ажлыг төлөвлөөд байна.
14. Аймгийн цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөө болон иргэд хууль зүйн туслалцаа авах нөхцөл байдалтай танилцсан. Тус байгууллага нь уулзалт, мэдүүлэг авах тусгай өрөөний зөвшөөрлийг авч гэмт хэрэгт холбогдсон болон гэрч хохирогчдыг хууль зүйн туслалцаа авах нөхцөл боломжоор хангаж өмгөөлөгчдийн нэрсийн жагсаалт утасны дугаар бүхий мэдээллийг байршуулсан байна.

Дорноговь аймгийн прокурорын газартай хамтран эрх зүйн боловсрол олгох сургалтыг зохион байгуулав. Сургалтад Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Прокурорын газрын нийт 42 алба хаагч хамрагдаж эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар ойлголт мэдлэгээ нэмэгдүүллээ. Сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, эрүүдэн шүүх гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж аливаа ялгаварлан гадуурхалтгүй, тэгш, хууль, дүрэм, журмын хүрээнд харилцах талаар чиглэл бүрээр мэдээлэл хүргэв. Мөн аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч С.Батмөнх-Очир, аймгийн Цагдаагийн газрын дэд бөгөөд хошууч Б.Батцолмон нар сургалтыг үр дүнтэй зохион байгуулагдсан талаар дурдаж сургалтад идэвхтэй оролцсон.

## **ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС**

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Төрийн өмчийн 22 эрүүл мэндийн байгууллагын 2022 оны санхүүгийн жилийн эцсийн тайланг ЭМЯ-д хүргүүлж нэгтгүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдол санал хүсэлтийг салбарын хэмжээнд гарган нэгтгэж АЗДТГ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын болон Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шагналаар шагнуулахаар нэр дэвшигчдийн материалыг даргын дэргэдэх удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудруу илгээв

Дорноговь аймгийн “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөн” 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын орлогч дарга Г.Март урилгаар ирж, эрүүл

мэндийн салбарт хэрэгжүүлж буй дэмжлэгт удирдлага, хөрөнгө оруулалтийн талаарх мэдээлэл хийж, эмч мэргэжилтнүүдэд ажлын амжилт хүслээ. Удирдах ажилтны зөвлөгөөнд Эрүүл мэндийн газрын удирдлагууд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд оролцож, 2022 оны эрүүл мэндийн салбарын ололт, амжилт, 2023 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Эрүүл мэндийн салбар нь 2023 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийн эрүүл аж төрөх зан үйлийг өөрчлөхөд чиглүүлэх юм. Зөвлөгөөнд JCI Монгол академийн зөвлөх лектор, багш нар урилгаар ирж, “Харилцаа ба хандлага”, “Багаар ажиллах ур чадвар” сэдвүүдээр салбарын удирдлагуудад манлайллын талаарх маш гайхалтай лекцүүд орж байгаагаараа онцлог байв.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор 2023 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ” аяны нээлтийг зохион байгууллаа. Нээлтийн үеэр аймгийн Засаг дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга нар үг хэлж аяны нээлтийг эхлүүлж, Эрүүл зөв зохистой хооллолт, хөдөлгөөн эрүүл мэндийн талаар эмчийн зөвлөгөө мэдээлэл өгч, биеийн жингийн индекс тодорхойлох, Танита аппаратаар оношилгоо хийж зөвлөгөө өгсөн. Аминдэмжүүлэлт хийн, Веган хүнсний амталгаат үзэсгэлэн гаргасан. Мөн Флаш моб, Хийн дасгал, Эрүүл мэндийн дасгал, Шугаман бүжиг хийж, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшихийг уриаллаа.

2023 оны 03 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Андрологи-Урологийн тасгийн эмч нар ирж эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 150 хүнд хийж, “Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүй” сэдвээр сургалт явуулж 300ш зөвлөмж тараасан.

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл шүдтэй хүүхдийн байгууллага, анги хамт олон болзолт уралдаанд оролцож буй 12 байгууллагын 39 албан хаагчдад Амны хөндийн эрүүл мэнд, Болзолт уралдааны шалгуурын талаар цахимаар сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрүүл шүд-Эрүүл хүүхэд аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 6,12 настай хүүхдийн шүдний цоорлын эрчим тархалт тодорхойлох албан бичгийг өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж 1, 6 дугаар ангийн 2302 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж цоорлын эрчим 6 настайд 3.5 тархалт 56.4%, 12 настайд 2.5 тархалт 60.8% байгааг тогтоосон.

Эрүүл шүд-Эрүүл хүүхэд аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшлийн шүдний эмч нар нийгмийн хариуцлагын хүрээнд Айраг, Зүүнбаян сумдуудад 7 хоногоор ээлжлэн ажиллаж үзлэгт нийт 266 хүн хамрагдсан ба үүнээс 0-5 насны хүүхэд 34 буюу /12.8%/, 6-18 насны хүүхэд 203 буюу /76,3%/, 19-оос дээш насныхан 29 /10.9%/-ийг тус тус эзэлж байна. Нийт үзлэгээс өвчлөлтэй 266 хүнийг илрүүлж, 470 шүдэнд эмчилгээ хийж, 225 хүнийг /84.5%/ эрүүлжүүлсэн.

АИТХ-ын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2 дахь зорилтын 2.1 дэх заалт,



Хүүхдэд ээлтэй орон нутаг зорилтот хөтөлбөрийн хүрээнд сурагчдад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг бий болгох зорилгоор “Эрүүл аж төрөхүй” эрүүл мэндийн хоёрдугаар олимпиадын удирдамжыг Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран боловсруулж ИТХ-руу зардлын тооцоололтой хамт хүргүүлсэн. Уг олимпиадад Ерөнхий боловсролын 21 сургуулийн 7,10 дугаар ангийн сурагчдыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хамруулахаар төлөвлөн бэлтгэж байна.

Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх “ГЭР ДҮҮРЭН ИНЭЭМСЭГЛЭЛ” аяныг ГБХЗХГ, Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Аяны хүрээнд 11 байгуулагатай хамтран ажиллаж эрсдэлт нөхцөлд амьдарч буй 134 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж өвчтэй 62 хүүхдийг илрүүлж уушгины хатгалгаатай 2 хүүхдийг эмнэлэгт хэвтүүлж өвчлөл илэрсэн хүүхдийн 78%-ийг эрүүлжүүлсэн. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдлүүлэх чиглэлээр ЕБС-ийн 495 сурагч, 75 эцэг эхчүүд нийт 570 хүнд 16 удаа зохион байгуулж 14 төрлийн 703 ширхэг гарын авлага тараасан. Цахимаар 47 төрлийн мэдээ мэдээлэл оруулж давхардсан тоогоор 5841 хандалт авсан байна. Үе тэнгийн найзууддаа зөв мэдээллийг хүргэж эрүүл мэндийн боловсрол олгох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр Замын-Үүд, Зүүнбаян, Мандах, Дэлгэрэх сумдуудад нийт 32 үе тэнгийн сургагч багш бэлдсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 5-11 дүгээр ангийн 141 сурагчдын дунд Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр уулзалт ярилцлага зохион байгуулж зөвлөгөө өгсөн.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Мишээлт мана ӨЭМТ-тэй хамтран Үе тэнгийн сургагч багш нар, ЕБС-ийн 9-12 сурагчдын төлөөлөлд Электрон тамхины хор хөнөөл, Сүрээ өвчин гэж юу вэ? сэдвүүдээр сургалт явуулж сурагчдын дунд АХА тэмцээн зохион эхний 3 байрыг шалгаруулж шагнасан. Үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан 2,3,5 дугаар сургууль, 9 дүгээр цэцэрлэгийн 11 бүлгийн 518 хүүхдэд Амны хөндийн эрүүл мэнд, Сүрээ, НҮЭМ сэдвээр сургалт зохион байгуулсан.

Монголын сумын эмч мэргэжилтний холбоотой хамтран Иххэт, Дэлгэрэх сумын сүрьеэтэй иргэдийн хавьтал 62 хүнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан

Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 11 дугаар ангийн 29 охидод Нөхөн үржихүйн эрүүл мэнд-Миний ирээдүйд фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. ЕБ-ын 2 р сургуулийн 8, 9 дүгээр ангийн сурагчдын төлөөллийг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үйл ажиллагааны хүрээнд амны хөндийн кабинет, хүүхдийн өрөө вакцины агуулахын байдал, хүйтэн хэлхээ байгууллагын талаар танилцуулж фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан.

Сайншанд сумын захирагчийн албаны 60 албан хаагчдад “Сүрьеэгийн халдвар урьдчилан сэргийлэлт сэдвээр сургалт зохион байгуулсан

19 эрүүл мэндийн байгууллагын 20 дархлаажуулалтын сувилагчаас дархлаажуулалт, хүйтэн хэлхээний талаарх мэдлэгийг тодорхойлох шалгалтыг

авахад дундаж үнэлэгээ 75,8%-тай үнэлэгдлээ. Шалгалтын үр дүнгээс дараагийн сургалтын хэрэгцээг тодорхойлон 4 сэдвээр хичээл бэлтгэн нэгжүүдэд хүргүүлсэн

Дархлаажуулалтын тухай 4 сэдвээр хичээл бэлтгэн 19 эрүүл мэндийн байгууллагад цахимаар хүргүүлж, Мишээлт мана ӨЭМТ-ийн 17 эмч мэргэжилтнүүдийг хамруулаад байна

УБ ТЗ-ийн харьяа байгууллагуудын 80 хүнд “Дархлаажуулалтын ач холбогдол” “Томуу томуу төст халдвараас сэргийлэхэд дархлаажуулалтын үр нөлөө”, “Жорлонгоо өөрчилье” сэдэвт сургалтыг зохион байгуулсан

АНЭ, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургууль, Политехник коллеж, Мишээлт Мана өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Зөв мэдлэг, дадалтай-Эрүүл оюутан” оюутан залуусын эрүүл мэндийг дэмжих аяны удирдамжийг ЭМГ-ын даргаар батлуулан Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургуулийн 144, Политехник коллежийн 112 нийт 256 оюутнуудыг нарийн мэргэжлийн ЧХХ эмчийн үзлэг, Хараа шалгуулах, ДОХ/Тэмбүү, Элэгний В,С вирус тодорхойлох шинжилгээнд хамруулсан. Үзлэгт Чих хамар хоолойн өөрчлөлттэй 43, Нүдний хараа муу-62 үүнээс шилээр засагдсан-22 шил тааруулах шаардлагатай-50, Архаг тонзиллит 20, Хулхин бөглөө 10, Хамрын таславч муруй 25, Харшлын гаралтай ринит 5, Хамрын хуучин гэмтэл 2, Гүйлсэн булчирхайн улаймал үрэвсэл 4, Ханиад шуухинаа 2, Хэнгэрэг цоорхой 1 оюутныг тус тус илрүүлж нарийн мэргэжлийн эмчийн эмчилгээ бичиж, зөвлөгөө өгч 2 дахь шатлалд илгээсэн. Үзлэгийн дараах эрүүлжүүлэх ажлыг АНЭ-тэй хамтран хуваарь гарган Шүдний өвчлөлттэй 47 оюутанд цаг олгон эрүүлжүүлсэн. Аяны хүрээнд 5 төрлийн сэдвээр 212 оюутанг сургалтад хамруулж эрүүл мэндийн боловсрол олгосон.

"Байгууллагын эрүүл мэндийн ажилтан бэлтгэх" сургалтыг зохион байгуулж 25 байгууллагыг хамрууллаа. Сургалтаар халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл, Илүүдэл жин таргалалт, Дархлаажуулалт, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хүргэж, эрүүл мэндийн ажилтны үнэмлэх олгосон.

13 сумын Эрүүл мэндийн төвүүд, 4 өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээг цахимаар хийж, ХАБЭА хариуцан ажилладаг ажилтан болон байгууллагын удирдлагуудыг арга зүйгээр хангаж ажиллав. Хуулийн хэрэгжилтийн дундаж 82%-тай сайн байна.

2022 оны 05 сараас эхэлсэн эрүүл мэндийн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоо”-нд аймгийн хэмжээнд 21890 иргэн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 30.4%-ийг эзэлж байна. Хамралтын байдлыг насны ангиллаар авч үзвэл:

- 68.7% (15031)-ийг 0-17 насны хүүхэд,
- 31.3% (6859)-ийг 18-аас дээш насны хүн ам байна.

2023 оны 03 сард (03 сарын -01-нээс 03 сарын 31):

Нийт 1652 хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулснаас

- 0-17 насны 873 хүүхэд,

18-аас дээш насны 779 хүн үзлэгт хамрагдснаас аймгийн нэгдсэн эмнэлэг 469, Замын Үүдийн нэгдсэн эмнэлэг 310 хүн хамруулсан байна

Улаанбаатар хотноо ХӨСҮТ - ээс зохион байгуулсан Олон эх сурвалжит тандалт хийх арга зүйн сургалтанд ЭМГ- аас 2 хүн оролцож мэдээллээр хангагдсан.

ЭМЯ, НЭМҮТ-өөс зохион байгуулсан Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулинд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зохион байгуулаан сургалтад аймгийн ЗДТГ-ын НБХ, ЭМГ-ын төлөөллүүд оролцож саналаа хэлж хэлэлцүүлээ.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор 2023 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан "ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ" аяны нээлтийг зохион байгууллаа. Нээлтийн үеэр 400 гаруй хүн оролцож, Аймгийн засаг дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга нар аяны нээлтийг эхлүүллээ. Эрүүл зөв зохистой хооллолт, хөдөлгөөн эрүүл мэндийн талаар эмчийн зөвлөгөө мэдээлэл өгч, биеийн жингийн индекс тодорхойлох, Танита аппаратаар оношилгоо хийж зөвлөгөө өгсөн. Мөн аминдэмжүүлэлт хийн, Веган хүнсний амталгаат үзэсгэлэн гаргасан. Флаш моб, Хийн дасгал, Эрүүл мэндийн дасгал, Шугаман бүжиг хийж, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшихийг уриаллаа.

Аймгийн Хийн дасгалын холбоо, Монголын Хийн дасгалын холбоотой хамтран Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж 13 байгууллагын 33 хүн хамрагдсан.

Эрүүл мэндийн сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийн 1 дүгээр улирлын тайланг өрх, сум, нэгдсэн эмнэлгүүдээс авч салбарын хяналтын газарт хүргүүлсэн.

Эрүүл Мэндийн Яамны салбарын хяналтын газрын даргын 2023 оны 03 сарын 30-ны өдөр баталсан 10-00/14 дугаартай “Хүнсний худалдааны газруудад импортлогдон, худалдаалагдаж буй тодорхой нэрийн бүтээгдэхүүнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Сайншанд сумын хүнсний худалдаа эрхлэгч 70 объект, 13 сумын хүнсний мэргэжилтнүүд 94 объектуудад урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэн сэрэмжлүүлэг зөвлөмж өгч ажилласан.

Барилгын зураг төсөл боловсруулдаг “Өлзий-Ш” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Даланжаргалан суманд баригдах 320 сурагчтай ерөнхий боловсролын сургуулийн ажлын зурагт урьдчилан сэргийлэх хяналт хийж улсын байцаагчийн дүгнэлт бичиж хүргүүлсэн.

Сургуулийн өмнөх боловсролын 6 байгууллагуудад урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нэгтгэсэн.

Сайншанд сумын 3 дугаар багт шинээр баригдах “Худалдаа үйлчилгээний цогцолборын барилгын ажлын зураг төсөл”, Замын-Үүд суманд баригдах “Нутгийн үйлдвэрлэл төслийн үйлдвэр үйлчилгээний барилгын ажлын зураг төсөл, “Рино констракшн” ХХК-ийн хүсэлтээр Замын-Үүд сумын чөлөөт бүсэд баригдах оёдлын

үйлдвэрийн ажилчдын байрны ажлын зурга төсөлд урьдчилсан хяналт хийж улсын байцаагчийн 3 дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

Сайншанд сумын 6 дугаар багт байрлах 640 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилга ашиглалтанд хүлээж авах комисст ажиллаж санал дүгнэлт өгсөн.

Сайншанд сумын эмийн сан болон эм ханган нийлүүлэх төвүүдэд “Нялх балчир хүүхдийн хүнсний тухай” сэдэвт сургалт зохион байгуулсан.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэргэдэх цагдан, хорих байранд хоригдож буй хоригдолд нэг хоногт олгож буй хоолны илчлэгийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

Аж ахуй нэгжийн хүсэлтээр Замын-Үүд сумын 1 дүгээр багт байрлах “Хүслийн мөнгөн үүд” ХХК-ийн эмийн сангийн байранд эрсдэлийн үнэлгээ хийж хяналт шалгалт зохион байгуулан 10-021-02/088-13 дугаартай Улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.

АШМУХ-ын үйлчилгээ эрхлэгчдэд салбарын сургалт зохион байгуулсан.

Чандмань илч” ОНӨХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Иххэт сумын төвийн цэвэр усны шугам шинэчлэх ажлын зураг төсөлд хариуцсан инженертэй зөвлөлдөж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/199 дугаартай захирамжаар батлагдсан ажлын хэсгийг ахлаж Мандах сумын иргэдийн гаргасан гомдлын дагуу тус сумын дуулгат гэдэг газарт шинээр гарсан булгийн ус орчны хөрсийг шинжилгээнд хамруулж ажилласан.

Эрүүл мэндийн яамнаас 2023 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Дорноговь аймгийн “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2023.03.23-нд зохион байгуулав. Тус зөвлөгөөнөөр салбарын хөгжил, чиг хандлага, орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэлэлцэж, салбарын 2022 оны ажлыг дүгнэн, 2023 оны үйл ажиллагаанд тусгах санал авч, хэлэлцлээ

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж буй шинэ технологи, инноваци, шилдэг туршлагаа иргэдэд танилцуулах “Эрүүл мэндийн технологи-2023” үзэсгэлэнг анх удаа Сайншандад 2023 оны 3 дугаар сарын 24-ны өдөр анх удаа цагийн хугацаанд Спортын ордон”-д зохион байгуулав. Тус үзэсгэлэнгийн арга хэмжээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд нэгдсэн эмнэлэг, УАУРСТ, өрх сумын эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл 120 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг оролцуулан 28 өртөөг ажиллуулан 250 иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч, үйл ажиллагаагаа сурталчилсан, “Шилдэг технологи нэвтрүүлэгч байгууллага”-ыг 5 нэр төрлөөр шалгаруулан батламж, мөнгөн шагнал олгосон.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг 2023 оны 3 сарын 20-нд хийж, сунгалт -3 ЭМБ,

шинээр -1 ЭМБ, хүчингүй -1 ЭМБ, 4 төслийг хэлэлцэж, шийдвэрлэсэн. ЭМГ-ын даргын 2023 оны А/38, 39, 40 дүгээр тушаалуудаар баталгаажуулсан.

Эмч нарын баярын өдрийг угтан “Эмч тандаа талархъя” сарын аянг зохион байгуулж, иргэдэд эмч мэргэжилтнүүддээ талархлаа илэрхийлэх боломжийг олгож, эмч нар мэргэжлээрээ бахархах сэтгэлийг төрүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, “Эрдэм шинжилгээний бага хурал”, “Эмч -спорт” арга хэмжээнүүдийг зохион байгуулав

Замын-Үүд суманд 2023 оны 03 сарын 22-ны өдөр бүртгэгдсэн эхийн эндэгдэлтэй холбогдуулан тус эмнэлгийн эх барихын тусламж үйлчилгээг эрчимжүүлэхээр аймгийн ЭМГ-ын ажлын хэсэг, АНЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтний хамт газар дээр нь ажиллаж, тус эмнэлгийн удирдлага, холбогдох эмч мэргэжилтнийг оролцуулан өргөтгөсөн хурал хийв. Хурлаас гарсан шийдвэрийг ЭМГ-ын 2023 оны 398 дугаар албан бичгээр хүргүүлээ

Нэгдсэн эмнэлгүүдийн 2023 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн үнэлгээ хийгдэж 18 багцад 16 ЭХНБ-тай гэрээ байгуулж, 13 багцад дахин тендер зарлаад байна.

Сумын эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах дахин зарласан тендерийн нээлт хийгдэж, шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагуудад мэдэгдэл хүргүүлээд байна.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Ажилд зуучлагдсан иргэдийн тоо: 26 буюу өмнөх оны мөн үеийнхээс 18 хувиар өссөн.

Шинэ ажлын байрны тоо: Шинэ ажлын байр бүртгэгдээгүй

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо: 241 буюу өмнөх оны мөн үеийнхээс 49 хувиар багассан.

Ажлын байрны захиалга: 66 буюу өмнөх оны мөн үеийнхээс 22 хувиар өссөн байна.

### **ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ:**

Нэг. Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгоход урьдчилсан байдлаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/05 дугаар тушаалаар байгуулан ажиллаж Зээлийн өмнөх сургалтыг “BEST” сургалтын төвтэй хамтран 01 дүгээр сарын 30, 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж нийт 62 иргэн сургалтад хамрагдсан. 2023 оны 02 дугаар сарын 06,14-ний өдрүүдэд 2 удаа хуралдаж нийт 43 иргэн, 4 аж ахуйн нэгжийн төслийг хянан үзэж, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батласан “Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын шаардлага хангасан 43 төслийг дэмжиж дараагийн шатны байгууллагад

дүгнэлтийг хүргүүлж 4 төслийг шаардлага хангаагүй төсөл гэж үнэлж дүгнэж ажилласан.

Хоёр. Нийтлэг үйлчилгээний хүрээнд:

2.Ажлын байрны захиалга, түүний зар мэдээ: 45 ААНБ-аас 69 ажлын байрны захиалгыг авч, ХХҮГазрын вэйб хуудас, ажил хайгч иргэдийн нэгдсэн групп, байгууллагын угтах зааланд хөлтэй слайданд байршуулан, тохирох мэргэжлийн ажил хайгч иргэд рүү утсаар холбогдон санал тавьж сонирхсон иргэдийн анкетыг хүлээн авч ажилласан.

3. Ажилд зуучлах үйлчилгээ: 1ААНБ-д 1 иргэнийг зуучилсан.

4.Хамтран ажиллах гэрээ: Хамтран ажиллах гэрээ 12 ААНБ байгуулсан байна.

5.Залуучуудын загвар төв: Төвөөр үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо: 292 иргэн Үүнд:

ü Ажилгүйдлийн тодорхойлолт: 15 иргэн

ü Загвар төвөөр үйлчлүүлэн мэдээлэл авсан болон ажил хайсан: 10 иргэн

ü Түр болон цагийн ажлын байрны захиалга: 2 аж ахуйн нэгж, 2 ажлын орон тоонд захиалга авч 1 иргэнийг зуучлан ажилласан.

6. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ:

1. "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ"-г Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 9,11,12 дугаар ангийн нийт 267 сурагчдад үзүүлж, хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг танилцуулан,арга хэмжээний хүрээнд:

1. Мэргэжил сонгоход тулгардаг хүндрэлүүд

2. Эрэлттэй ажил мэргэжил

3. Их дээд сургуулиудын тэтгэлэгт хэрхэн хамрагдах вэ?

4. Хандлага, түүний нөлөө зэрэг сэдвүүдээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

2. 2023 оны 2 дугаар сарын 8 ны өдөр Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 9-12 дугаар ангийн 50 сурагчдад, 2 дугаар сарын 9 ний өдөр, 5 дугаар сургуулийн 60 сурагчдад тус тус Мэргэжил сонголтын талаарх сургалтыг зохион байгуулан ажилласан.

2023 оны 2 дугаар сарын 15 ны өдөр Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны 10-12 дугаар ангийн 50 сурагчдад мэргэжил сонголтын талаар сургалт мэдээлэл хийж ажилласан.

Гурав. Бусад үйл ажиллагааны хүрээнд:

1.Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем EJOB платформыг танилцуулах сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн ажил олгогч байгууллагуудад зохион байгуулж, 91 байгууллагын 130 удирдлага, хүний нөөцийн ажилтнууд хамрагдсан.

Сургалтын үр дүнд: 117 байгууллага EJOB платформ-д ажил олгогчоор бүртгүүлж, 69 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг оруулан ажилласан.

2. EJOB платформыг ажил олгогчид зориулан гарын авлага бэлтгэж 100 ширхгийг тараан ажилласан.ejob.gov.mn программын сургалтын зар, шторк хийж байгууллагын пэйж хаяг, орон нутгийн DTV телевизэд мэдээллийг иргэдэд өгч ажилласан.

3. 2023.02.15-ны өдөр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв болон цагийн ажлын зар авах, цагийн ажилд зуучлах,ажил хайгч болон хувиараа бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй залуучуудад зориулсанүе шаттай модуль сургалтын талаар мэдээ мэдээлэл өгч байгууллагын пэйж хуудсаар шууд лайв дамжуулсан.

#### Хандалт-585

2023 оны 02 дугаар сарын 16 ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга, нарийн бичиг нарыг чадавхжуулах сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төв, Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан. Сургалтад сумдын салбар зөвлөлийн дарга, нарийн бичиг нийт 29 ажилтан албан хаагч оролцож сертификатаа гардан авлаа. Уг сургалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал, 2023 онд Хөдөлмөрийн аюулгүй байдалын хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн талаар Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэлтсийн дарга доктор, профессор Н.Энхтайван мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Дөрөв. Төсөв, санхүүгийн хүрээнд:

1. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батласан “Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу төрийн банкаар дамжуулан 14 иргэн, 2 аж ахуйн нэгжид нийт 594.4 сая төгрөгийн зээлийг олгосон.

#### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

үйНийгмийн халамжийн сангийн улсын төсвөөс санхүүждэг зардалд Төрийн аудитын газрын 2023 оны 02 сарын 24-ний өдрийн 1-6/231 тоот албан бичгээр, орон нутгийн төсвөөс санхүүждэг зардалд 2023 оны 02 сарын 24-ний өдрийн 1-6/102 тоот албан бичгээр тус тус өөрчлөлтгүй санал дүгнэлт авсан.

үйХХҮГазрын санхүүгийн ил тод байдлын самбарт 2023 оны батлагдсан төсөв, сарын гүйцэтгэлийн мэдээ, зарцуулалтын эрх хүсэлт баталгааг байршуулсан.

ÿИ халамж нэгдсэн системээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргасан 507 иргэний хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн.

ÿ3-р сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг иргэдийн дансруу илгээлээ. Үүнд:

vЦалинтай ээжийн тэтгэмж 2622 иргэнд 126,5 сая төгрөг

vЖирэмсэн эхийн тэтгэмж 475 иргэнд 17,0 сая төгрөг

vНасны хишиг 23 иргэнд 1,5 сая төгрөг

vАлдарт эхийн одонгийн тэтгэмж 150 иргэнд 17,1 сая төгрөг

vХаламжийн тэтгэвэр 1312 иргэнд 369,0 сая төгрөг

vАсаргааны тэтгэмж 1060 иргэнд 95,3 сая төгрөг

vАмьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж 500 иргэнд 102,0 сая төгрөг

vАхмад настны хөнгөлөлт тусламж 145 ахмадад 28,3 сая төгрөг

vХөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламж 95 иргэнд 25,1 сая төгрөг

vХүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 158 өрхийн 303 том хүн, 408 хүүхдэд 8,1 сая төгрөг нийт 7093 иргэнд 789.9 сая төгрөг олгосон.

ÿ“Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газарт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” ажлын хэсгийг тушаалын эхийг боловсруулж ХХҮГ-ын даргын 2023.03.21-ний өдрийн А/14 дугаар тушаалаар баталж гаргуулсан. Үнэлгээний хорооны хурлыг 03 сарын 27-ны өдөр хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

ÿНийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” нэгдсэн удирдамж батлагдсан бөгөөд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон авч буй иргэд нийгмийн даатгалын сангаас давхар тэтгэвэр тогтоолгон авч буй эсэхийг хянах зорилгоор 2021 оноос хойш тэтгэвэр авагчдын нэрсийг гаргаж хүргүүлээ.

ÿ Сайншанд сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж 27 иргэний өргөдлийг хэлэлцэж 25 иргэний өргөдлийг бүрэн шийдвэрлэж 1 иргэний хүсэлтийг дахин нягтлахаар хойшлуулж, 1 иргэний хүсэлтийг буцаасан.

ÿ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “гэрийн асрамж халамжийн үйлчилгээ”-г 2023 онд хэрхэн хэрэгжүүлэх, үр дүн гаргах талаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тус үйлчилгээг үзүүлэхээр магадлан итгэмжлэл авсан Улаан загалмайн нийгэмлэгтэй уулзалт зохион байгууллаа. Цаашид үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж хүн ам олонтой Замын-Үүд, Айраг сумдад үйлчилгээг хэрэгжүүлэх талаар санал солилцлоо.

ÿ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг батлагдсан хуваарийн дагуу 03.07 өдөр зохион байгуулж 20 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа



шаардлагатай эсэхийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Ингэснээр аймгийн хэмжээнд 272 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэгдсэн байна.

ÿ Насан туршийн боловсрол төвтэй хамтран лаа, саван, давсан урлал, сугаж урлалын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэн хамрагдсан.

ÿ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем турших буюу гар утасны аппликейшн хэрхэн ашиглах хэрэглэхтэй холбоотой PIMIS программын сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй 14 иргэнд мэдээлэл хүргэж хамрууллаа.

ÿ “Халамжаас-хөдөлмөрт 222” өдөрлөгийг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд зорилтот бүлгийн 60 эмэгтэйчүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгөөр ХХҮГ-с төсөл хөтөлбөрт хамрагдаж бизнесээ амжилттай хэрэгжүүлж байгаа эмэгтэйчүүдийн 2 төлөөлөл бизнесээ хэрхэн амжилттай явуулах боломж нөхцөл, туршлага, ур чадвараа бусаддаа хуваалцаж мөн 2023 онд хэрэгжих төсөл хөтөлбөр, нийгмийн халамжийн сангийн бүлгийн төслийн талаар мэдээлэл хүргэсэн.

ÿ Хууль, тогтоомж тогтоол шийдвэр, Сайдын тушаал, төрийн нарийн бичгийн даргын тушаал, албан даалгаврын 1 дүгээр улирын хэрэгжилтийг гаргаж 03 сарын 03-ны өдрийн 122 албан бичгээр ХХҮЕГ-т хүргүүлээ.

### **СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **ЗОРИЛТОТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ:**

Ø Соёлын яамны санаачилгаар Монгол орон даяар гуравдугаар сарын эхний 7 хоногийг “Музейн нээлттэй өдөр” болгон зарладаг уламжлалын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн музейг үндэсний түүх, соёл, өв уламжлал, ёс заншлын сэдэвтэй тусгай үзэсгэлэн гаргаж иргэд, олон нийтэд нээлттэй үнэ төлбөргүй үйлчилсэн. “Музейн нээлттэй өдрүүд” аяны хүрээнд Музейн үзүүллэгийн танхимаар 817 том хүн, 1601 хүүхэд, нийт 2418 хүнд үйлчилгээ үзүүлсэн.

Ø Соёлын яамнаас гуравдугаар сарын эхний 7 хоногийг “Музейн нээлттэй өдөр” болгон зарладаг бөгөөд Дорноговь аймагт зохион байгуулагдаж байгаа “Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг тохиолдуулан Музей сургалт судалгааны төв тэмээний өв соёл, ахуйн эд хэрэглэлээр “ИХ ГОВИЙН ТЭМЭЭЧИД” тусгай үзэсгэлэн гаргасан. Нээлтэд Соёл урлагийн газрын хамт олон, Мандах сумын Засаг дарга Б.Угтахбаяр, Хатанбулаг сумын Засаг дарга С.Эрдэнэболд нар малчдын төлөөллийн хамт хүрэлцэн ирж сонирхсон.

Ø Монгол улсын Засгийн газрын, Соёлын яамны соёлын бодлогын төвд хичээллэж байгаа “Соёлын өв-музейн боловсрол”-ын кредит тооцох 10 хоногийн танхимын сургалтад Дорноговь аймгийн 10 музейн мэргэжилтэнг хамруулсан.

Ø Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн ажлын хүрээнд Соёл, урлагийн газрын дэргэдэх “Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл”-өөс санаачлан Ноён хутагт Данзанравжаа, Өвөрбаясгалант Хамарын хийд, Ханбаянзүрх хайрханы талаар “Хөтөч тайлбарлагч” бэлтгэх сургалтыг 60 гаруй иргэдийн дунд зохион байгуулсан.

Ø Соёл урлагийн газар Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдаар соён гэгээрэл, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, хяналт-шинжилгээ, статистик мэдээ болон төсөв санхүүгийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч байгууллагын нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудал, санал, хүсэлтийг сонсож, үйл ажиллагаатай танилцлаа.

Ø Соёлын салбарын ёс зүйн зөвлөл хуралдаж, энэ онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батласан.

#### ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ТАЙЛАН:

Ø Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр жил бүр зохион байгуулагддаг Жендэрийн үндэсний хорооны “Надаас, танаас, биднээс эхлэлтэй” уриан дор үндэсний хэмжээний “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ-2023” аянд Дорноговь аймгийн Соёл, урлагийн газар нэгдэж байгууллагын цахим хуудсаараа дамжуулан олон нийтийн жендэрийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, ялгаатай байдлыг багасгахыг уриалсан мэдээ мэдээллийг байршуулсан.

Ø Чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх сургалтад хамрагдсан.

Ø “Мөнгөн модод-2022” оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчийг шалгаруулах наадамд оролцогчдын материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газарт хүргүүлсэн.

Ø Нэгж байгууллагын үнэ тарифын мэдээг нэгтгэж Соёлын яамруу хүргүүлсэн.

Ø Аймгийн бүх музейн хаяг, байршлын судалгааг, соёлын өвийн үндэсний төвд нэгтгэн хүргүүлсэн. Аймгийн түүхэн дурсгалт барилга архитектурын дурсгалын мэдээ, хууль бус эрсдэлд өртсөн дурсгалын мэдээлэл, байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж буй дурсгалын мэдээлэл, соёлын өвийн тоног төхөөрөмж сумдын соёлын өвийн ажилтны мэдээлэл, цалин хөлсний мэдээг нэгтгэж Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газарт хүргүүлсэн

Ø Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтад урлаг, уран бүтээл хариуцсан мэргэжилтэн Т.Одончимэг хамрагдсан.

Ø Соёлын салбарын санхүүгийн нэгтгэл тайланг Соёлын яамруу хүргүүлсэн.

Ø Соёлын яамны салбар хариуцсан эрх бүхий албан тушаалтан Т.Ууганбаярын зохион байгуулсан "Салбарын ЭБАТ-уудад мэдээлэл хүргэх" цахим уулзалтад Соёл, урлагийн газрын дарга, хэлтсийн дарга, ЭБАТ 3 хүн хамрагдаж мэдээлэл авсан.

Ø Салбарын 2022 оны жилийн эцсийн "Хөрөнгө санхүүгийн мэдээ" гаргах цаглабар хугацаа болсонтой холбогдуулан 18 байгууллагын холбогдох албан тушаалтанд мэдээлэл хүргэн ажиллалаа.

Ø Соёл урлагийн салбарын шилэн кабельд холбосон ажлын явц, тайлан мэдээг хавсралтын дагуу Соёлын яамруу хүргүүлсэн.

Ø Соёлын салбарын дэд бүтэц болон техникийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааг Соёлын яамруу хүргүүлсэн.

## МУЗЕЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

Ø “Монгол гэр” боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах 2,0 сая төгрөгийг зарцуулах тушаал гаргав. Ажил гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 60%-тай явагдаж байна.

Ø 1 дүгээр улирлын музейн үйл ажиллагааны статистик мэдээг СУГ-т хүргүүлэв.

Ø “Музейн нээлттэй өдрүүд” аяны хүрээнд Музейн үзүүллэгийн танхимаар 817 том хүн, 1601 хүүхэд, нийт 2418 хүнд үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.

Ø “Музейн үзүүллэгийн танхимаар 65 том хүн, 483 хүүхэд, 1 гадаад, нийт 549 хүнд үйлчилгээ үзүүлсэн. 3 сард нийт 325,000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Ø “Музейн нээлттэй өдрүүд” аяны хүрээнд “Их говийн тэмээчид” үзэсгэлэн зохион байгуулсан. Үзэсгэлэнд тэмээтэй холбогдох 45 эд зүйлсийг дэлгэн үзүүлсэн. Үзэсгэлэнг нийт 2418 хүн үзсэн.

Ø “Музейн нээлттэй өдрүүд аян”-ы хүрээнд зохион байгуулсан Мандала болон Шагайн наадгай боловсролын хөтөлбөр 233 хүн хамрагдсан.

Ø Монгол цэргийн өдрийг тохиолдуулан музейн сан хөмрөгт хадгалагдаж буй цэрэг дайны холбогдолтой үзмэр эд өлгийн зүйлсийг дэлгэн харуулсан “Монгол цэрэг” үзэсгэлэн 3 сарын 16-ны өдөр нийтэд дэлгэж 7 хоногийн хугацаатай үзэгчдэд хүрсэн.

Ø Соёл урлагийн газрын дэргэдэх Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн санаачилгаар аймгийн Соёл урлагийн газар болон Говийн ноён хутагтын музейтэй хамтран Ноён хутагт Данзанравжаа, Өвөрбаясгалант хамарын хийд, Ханбаянзүрх хайрханы талаар “Хөтөч тайлбарлагч” бэлтгэх сургалтыг 03 сарын 16 –ны өдөр Соёмбо цогцолборт зохион байгууллаа. Энэхүү сургалтанд 60 төрийн албан хаагч болон иргэд хамрагдсан байна.

Ø “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Галба өөш долоодын сав газрын захиргаатай хамтран гар зургийн үзэсгэлэн зохион байгуулав.

Ø Уртын дууны дугуйлан хичээллэж эхэлсэн. Сургалтанд одоогоор 20 хүн хамрагдаж байна.

Ø “Өв алтан эрдэнэ” өсвөрийн морин хуурч, уртын дуучдын уралдааны удирдамжийг батлуулан хамтран зохион байгуулалтын ажил явагдаж байна

Ø Сан хөмрөгт хадгалагдаж буй түүх, соёлын үнэт үзмэрүүдээс дээжлэн "Дорноговийн шилдэг үзмэрийн дээжис" гэрэл зургийн цомог 300 ширхэгийг хэвлэлтээс хүлээн аваад байна.

**Цаг үеийн ажлын тайлан:**

Ø Онцгой байдлын газраас байгууллагын албан хаагчдад зориулан Галын аюулгүй байдлыг хангах болон газар хөдлөлтийн аюулын үед хэрхэн ажиллах талаарх сургалтын 03 сарын 15-ны өдөр зохион байгуулав. Сургалтанд 7 албан хаагч хамрагдсан.

Ø Соёлын өвийн үндэсний төвд музейн байгууллагын сүүлийн 10 жилийн хугацаанд сэргээн засварласан үзмэр эд өлгийн зүйлс болон барилгын засварын талаарх мэдээлэл судалгааг хүргүүлэв.

Ø “Соёлын өв-музейн боловсрол” танхимын кридет тооцох богино хугацааны сургалтанд 2 албан хаагч Улаанбаатар хотод хамрагдсан.

Ø Аймгийн эрүүл мэндийн газраас “Эрүүл мэндийн ажилтан” бэлтгэх буюу байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалтанд 1 албан хаагч хамрагдсан.

Ø Соёлын яам болон аймгийн Соёл урлагийн газарт байгууллагын интернет, шилэн кабель болон барилгын талаарх судалгааг хүргүүлсэн.

Ø 1 дүгээр улирлын нярвын тайлан гаргав.

Ø Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн н.Адьяатай хамтран байгууллагын гамшгийн эрдлийн үнэлгээг хийв.

Аймгийн ҮЭХ болон байгууллагны ҮЭХороо хамтран “Эрүүл зөв амьдралын хэв маяг таны гарт” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Соёл урлагийн салбарын Ёс зүйн зөвлөлийн хуралд гишүүн Х.Анхтуяа оролцов.

“Хайрлан хүндэтгээ” аянд нэгдэж жендерийн талаарх мэдээллийг байгууллагын Dornogobimuseum фэйсбүүк хаягаар дамжуулан хүргэж байна.

## **САРАН ХӨХӨӨ ТЕАТР**

Зорилтот арга хэмжээний хүрээнд:

Ø Дорноговь аймгийн тэмээчдийн холбооноос зохион байгуулж буй “Их говийн тэмээчид” нээлтийн арга хэмжээнд тус театрын 34-н уран бүтээлчид 1000 гаруй иргэдэд 9 урлагийн номероор 1 цагийн бүрэн хэмжээний урлагийн тоглолтоор үйлчилсэн.

Ø “Дорноговь аймгийн малчдын нэгдсэн зөвлөгөө”-ний арга хэмжээнд тус театрын 34 уран бүтээлчид 1 цагийн бүрэн хэмжээний тоглолтыг толилууллаа.

Ø Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярт зориулсан тус театрын уран бүтээлчид PRO MUSIC продакшнтай хамтран “Монголжингоо” тоглолтыг зохион байгуулсан. Тоглолтыг 350 үзэгч үзсэн.

Ø “Шашин урлагийн цэнгүүн”-ийг зохион байгуулсан. Театрын 34 уран бүтээлчийн 1 цагийн тоглолтыг 200 гаруй үзэгч үзсэн.

Цаг үеийн ажлын тайлан:

Ø “Мөрдөстэй ахмадууд” арга хэмжээнд оролцсон.

Ø Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярын өдрийн үйл ажиллагаанд оролцсон.

Ø “Саран охин-Хөхөө хүү”-гийн адал явдал танин мэдэхүйн хүүхдийн жүжгийг ЕБС 1-5 дугаар ангийн 2400 хүүхэд багачуудад хүргэж үүнээс нийгмийн хариуцлагын хүрээнд 200 хүүхэд багачуудыг үнэ төлбөргүй толилууллаа.

Ø Шүүхийн шийдвэрийн ерөнхий газрын “Говийн бүсийн спорт”-ын наадам 2023 оны 03-р сарын 23-нд Спорт цогцолборт зохион байгуулж Саран хөхөө театрын 5 уран бүтээлч оролцсон.

Ø Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй Эрүүл мэндийн технологи-2023” үзэсгэлэн арга хэмжээг театрын 2 уран бүтээлч оролцсон.

Ø Спорт ордонд Хөл бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээний нээлтийг зохион байгуулсан.

Ø Дэлхийн театрын баярын дөрийг тохиолдуулан Драм ангийн санаачлагаар “3.27” тэмцээнийг театрын захиргаа болон уран сайхны зөвлөлийн дэмжлэгээр зохион байгуулсан.

Ø “Томүжи акдеми”-н эвент арга хэмжээг Аймгийн боловсрол шинжлэх ухааны газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан. Ерөнхий боловсролын 6-12 ангийн сурагчдын 250 орчим сургчид хамрагдсан.

Ø Театрын ҮҮТехникийн анги хуваарьт сургалтаа зохион байгуулсан. Тус сургалт нь “Монгол улсын зэвсэгт хүчин, халдашгүй дархан байдал”-ын талаар мэдээлэл өгсөн нь эх орон Монгол улсаараа бахархах сэтгэл төрүүлсэн сайхан сэдэвтэй сургалтыг зохион байгуулсан.

## **ТӨВ НОМЫН САН**

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

Төв номын сан Гуравдугаар сарын байдлаар 916 уншигч үйлчлүүлснээс танхимаар 130 хүн хамрагдсан. Танхимаар ном олголт-1467, Гэрээр ном олголт-594, Зөөврөөр /Хүүхдийн уншлагын танхим/ ном олголт-216, “Аз жаргалын өрөө”-нд 40 хүүхэд зочилсон. “Шидэт үзэг” дугуйлангийн багш Хүүхдийн зохиолч Л.Мөнхбат 55 хүүхдэд ном зохиол уншиж өгч хүүхдүүдтэй харилцан ярилцаж хамтран ажилласан.

Цаг үеийн ажлын тайлан:

Ø Монгол улсын Соёлын яамнаас орон даяар зохион байгуулж буй “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээний хүрээнд “Их говийн тэмээчид” тусгай үзэсгэлэнгийн нээлт, “Малчдын зөвлөгөө”, Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хуулийн төсөл болон хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан хуулийн төслийг танилцуулж санал авах уулзалт хэлэлцүүлэг, Америкийн соёл мэдээллийн төвөөс зохион байгуулсан “Хувь хүний хөгжил мэдлэг олгох” арга хэмжээ зэрэг үйл ажиллагаанд 12 албан хаагч оролцсон.

Ø Америкийн соёл мэдээллийн төвөөс сурагчдыг чадавхжуулах, цаашид олон сайн дурын ажлуудыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган нээлтийн арга хэмжээг эхлүүлсэн. Уг арга хэмжээнд 60 гаруй хүүхэд оролцлоо.

Ø Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Төв номын сангаас “Миний нандин эрдэнэ” уран бүтээлийн уралдааныг зарласан. Уралдаанд 36 бүтээл ирснээс эхний 4 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Ø Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ШШГГ-ын цагдан хорих байранд хүмүүжиж байгаа иргэдийн дунд хайртай Ижидээ /ханьдаа, эгчдээ/ хэлж чадаагүй, хэлэхийг хүсдэг сэтгэлийн нандин үгсээ хэлэх боломжийг олгох, ухаарал гэгээрэл, уучлал хүссэн "Үрсийн зүрхний үг" захидал бичих уралдааныг 9 дэх жилдээ зохион байгуулсан. Уралдаанд 18 захидал ирсэнээс эхний 3 байрыг шалгаруулан дурсамж, номоор шагнасан.

Ø Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Чанарын форум”, “Эмэгтэйчүүдийн хөгжил, хөдөлмөр эрхлэлтэд ҮЭ-ийн оролцоо” чуулга уулзалт, Аймгийн ҮЭХ-ноос “Хөдөлмөрийн харилцааны цалин хөлсийн бүртгэлийн бодлого”, Музейн сургалт судалгааны төвөөс зохион явуулсан “Хөтөч тайлбарлагч”, ЭМГ-аас зохион явуулж буй “Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх”, Төрийн албаны шинэтгэл онлайн цахим зэрэг сургалтуудад 10 албан хаагч хамрагдсан.

Ø “Алтан бийр” яруу найргийн сонгодог үдэшлэг арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан байгууллага болон 15 яруу найрагчид оролцсон. Үдэшлэгийн арга хэмжээнд 100 гаруй төрийн албан хаагч, иргэд, яруу найрагчид оролцсон.

Ø Дэлхийн үлгэрийн хаан Х.К.Андерсений төрсөн өдрийг тохиолдуулан 04 дүгээр сарын 2-ныг олон улс оронд “Хүүхдийн номын өдөр” болгон тэмдэглэдэг билээ. Хүүхдийн уншлагын танхимд номын үзэсгэлэн болон Хүүхдийн зохиолч Л.Мөнхбаттай “Уншсан номоо ярилцъя” уулзалтыг зохион байгуулсан.

Ø Хүүхдийн номын фондоос Үндсэн фондод орос номыг хүлээлгэн өгч, номын тооллого болон үндсэн фондын номын тавиурыг солих ажлуудыг зохион байгуулан ажилласан.

Америкийн соёл мэдээллийн төв

Ирсэн хүмүүсийн тоо 608

Үйл ажиллагаа зохион байгуулагдсан 28

Үйл ажиллагаанд ирсэн хүмүүсийн нийт тоо 277

Ном уншсан хүмүүсийн тоо 13

Засгийн газрын зочлолтын тоо 0

Ø Junior empowering program гэдэг нь өсвөр насныхныг чадваржуулах хөтөлбөр бөгөөд орон нутгийн 10-12 дугаар ангийн болон гар уеаг авсан сурагчдад зориулсан хөтөлбөр ба сурагчдад хувь хүний хөгжлийн мэдлэг олгох

нийт 7 өдрийн хөтөлбөр юм. Мөн нэг өдрийн сургалт дунджаар 2-4 цаг үргэлжилдэг. Сургалтад нийт 15 хүүхэд хамрагдсан.

### **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

1. Биеийн тамир, спортын газрын дэргэдэх спортын секц дугуйлан хэвийн хичээллэж байна.

2. Нөхөрлөл лигийн тоглолт 2023 оны 03 дугаар сарын 07, 14, 21-ний өдрүүдэд Спорт цогцолборт болов. Нөхөрлөл лигийн хаалт 03 дугаар сарын 25-ны өдөр Спорт цогцолборт болж, хагас жилийн хугацаанд өрсөлдсөн Нөхөрлөл лиг сагсан бөмбөгийн тэмцээнд Ирвэсүүд, Аравт, Шонхрууд, Мазаалай, Шандын хүлгүүд, Хилэнц гэсэн 6 баг өрсөлдсөнөөс 1-р байранд Шандын хүлгүүд баг, 2-р байранд Мазаалай баг, 3-р байранд Шонхрууд баг тус тус шалгарсан байна.

3. Монголын хүүхдийн зуны спортын VII наадмын анхан шатны тэмцээний цахим бртгэлтэй холбоотой цахим сургалтыг Биеийн тамир, спортын улсын хорооноос 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулав. Тус цахим сургалтад тус газрын Усан спортын дасгалжуулагч Э.Мөнгөнцэцэг хамрагдав. Хүүхдийн зуны спортын VII наадмын анхан шатны тэмцээнд оролцох баг тамирчдын мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хорооны [cranel.gov.mn](http://cranel.gov.mn) програмд шивэх ажил хийгдээд дуусах шатандаа явж байна. Хүүхдийн зуны спортын VII наадамд Дорноговь аймгаас сагсан бөмбөг, волейбол, даам, хөлбөмбөг, хөнгөн атлетик, дугуй, бокс, жүдо бөх, чөлөөт бөх, самбо бөх, гандбол гэсэн спортын төрлүүдээр 360 гаруй баг тамирчид оролцохоор бүртгүүлсэн байна.

4. Эх орончдын өдөрт зориулсан улс, аймгийн цолтой бөхчүүдийн хүчит бөхийн барилдаан 03 дугаар сарын 01-ний өдөр Спорт цогцолборт болов.

5. Эх орончдын өдөрт зориулсан МАН-ын спортын арга хэмжээ 03 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Спорт цогцолборт болов. Сагсан бөмбөг, волейбол, дартс, буухиа гэсэн спортын төрлөөр 17 баг өрсөлдлөө.

6. Чөлөөт бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Спорт цогцолборт 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд Дорноговь аймгийн 9 сумын нийт 130-аад тамирчид оролцлоо.

Багийн дүнгээр:

1-р байранд Биеийн тамир спортын газар

2-р байранд Ю.Даваажаргал дасгалжуулагчтай Замын-Үүд сум

3-р байранд Э.Зулхүү дасгалжуулагчтай Айраг сум

Шилдэг дасгалжуулагчаар П.Сэргэлэн-Од (Хатанбулаг сум)

Шилдэг эмэгтэй тамирчнаар Э.Отгонжаргал (БТСГ)

Шилдэг эрэгтэй тамирчнаар Э.Дашням (Улаанбадрах сум) тус тус шалгарсан байна.

7. Ноён Хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жил, Дорноговь аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмыг угтан “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ”-

2023 наадам 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдлаа. Уг наадмын Тэмээн поло тэмцээнийг БТСГ зохион байгуулж ажиллалаа.

8. Жүдо бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Спорт цогцолборт 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдав. Дорноговь аймгийн 8 сумын нийт 160 гаруй тамирчид оролцлоо.

Багийн дүнгээр:

1-р байрт Биеийн тамир спортын газар

2-р байрт С.Гантулга дасгалжуулагчтай Бор-Өндөр сум

3-р байрт М.Батдэлгэр дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг

Шилдэг эрэгтэй тамирчнаар П.Сүхбат (БТСГ)

Шилдэг эмэгтэй тамирчнаар Б.Сарангоо тус тус шалгарсан байна.

9. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 03 дугаар сарын 07-ны өдөр Саран хөхөө театрт зохион байгуулсан “Чанарын форум”-д байгууллагын 5 албан хаагч хамрагдав.

10. Спорт цогцолборт 03 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд АЗЗА ТӨХК-ийн Зүүн бүсийн урлаг, спортын наадам боллоо. Зүүн бүсийн уулзалтад Дорноговь, Сүхбаатар, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Налайх, Багануур, Борхойн зам спортын 5 төрлөөр өрсөлдсөн байна.

11. Спортын ордонд 03 дугаар сарын 10-ны өдөр ЭХУХ-ийн 2 дугаар ангийн спортын арга хэмжээ боллоо.

12. Спортын ордонд 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Замын 4 дүгээр ангийн спортын арга хэмжээ болж өндөрлөв.

13. Дорноговь аймгийн 2023 оны өсвөрийн аймгийн аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээн 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд боллоо. Тус тэмцээнд Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Сайхандулаан, Сайншанд, Улаанбадрах, Зүүнбаян, Эрдэнэ гэсэн 10 сумын 130 тамирчин оюун ухаанаараа өрсөлдсөн байна.

14. Зэвсэгт хүчний 102 жилийн ойн хүрээнд Хүчний байгууллагуудын дундах спортын арга хэмжээ Спорт цогцолборт 03 дугаар сарын 15-ны өдөр болов.

15. Байгууллагын албан хаагчдын дундах спортын арга хэмжээг Волейбол, ширээний теннис, олс таталт, буухиа, дартс гэсэн төрлүүдээр 03 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Энэ ажил байгууллагын Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд хийгдэж байгаа ажил юм.

16. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Нийтийн хөлбөмбөг” төсөл, “Нээлттэй Дорноговь” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулагдаж буй 21 аймгийн “Футзалын Үндэсний Цом” аварга шалгаруулах хөлбөмбөгийн тэмцээн Спорт цогцолборт 03 дугаар сарын 26-ны өдөр эхэлж үргэлжлэн явагдаж байна.



17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2023 оны Говийн бүсийн 6 төрөлт тэмцээн Спорт цогцолбор болон Спортын ордонд 03 дугаар сарын 23-ны өдөр боллоо. Тус тэмцээнд Төв аймаг, Төв аймгийн Албадан эмчилгээний газар, Дундговь аймаг, Өмнөговь аймаг, Дорноговь аймгууд оролцсон байна.

18. Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат шинэ сэргэлтийн бодлого” сургалтад байгууллагын Биеийн тамирын арга зүйч, Бичиг хэрэг, архивын ажилтан нар 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд хамрагдлаа.

19. Байгууллагын албан хаагчид нийтийн хуваарьт талбайг цэвэрлэх ажлыг 03 дугаар сарын 24-ний өдөр хийж гүйцэтгэлээ.

20. “Эрүүл мэндийн технологи-2023” эмнэлгийн оношилгоо эмчилгээний шинэ технологи, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн 03 дугаар сарын 24-ний өдөр Спорт цогцолборт болов.

21. Спортын ордонд 03 дугаар сарын 25-ны өдөр Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын 5 төрөлт тэмцээн болов.

22. Саран хөхөө театрт 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан Нийгмийн даатгалын тухай багц хуулийн хэлэлцүүлэгт байгууллагын 5 албан хаагч хамрагдлаа.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Хүүхдийн хөгжил оролцоо, эрхийг хамгаалах чиглэлээр:

Тайлант сард “Уран жиргээ 2023” уран уншлагын тэмцээн, монгол бичгийн “Сайхан бичигтэн” “Миний эх орон” гар зургийн уралдаан, “Рубик шоо” сонирхогчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулж нийт 225 хүүхэд оролцоноос шагналт байранд 39 хүүхдийг шалгаруулж байгууллагын хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх зардлаас 2,1 сая төгрөгийг зарцуулсан. Дээрх тэмцээн уралдаанд оролцсон хүүхэд багачууд өөрийгөө дайчлах, дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг таниулах, сурталчлах, монгол өв уламжлал, ёс заншил, хэл соёл, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхний оюун ухаан, сэтгэн бодох чадвараа нээн хөгжүүллээ.

Аймгийн Хүүхэд хөгжлийн төвийн дэргэдэх уран зураг, уран нугаралт, шатар, монгол бичиг, рубик шоо, математик, илтгэх урлаг, компьютерын хэрэглээ, программын 10 төрлийн дугуйланд тайлант хугацааны байдлаар 180 хүүхэд суралцаж өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлж байна. Хөгжлийн төвийн үйл ажиллагаанд мөрдөх дотоод журам, дугуйлан хичээллүүлж буй багш нартай байгуулах “Хамтран ажиллах” гэрээг байгууллаа. Цаашид дугуйлангуудын тогтвор суурьшилтай хичээллэх нөхцөлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ суралцах хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэх, хүүхдүүд хөгжлийн төвөөр хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

“Тэгш оролцоо-хязгааргүй боломж” уриатай Монголын Хүүхдийн Зөвлөл нь 21 аймаг, 9 дүүрэгт салбартайгаар хүүхдийн өөрийн удирдлагын дээд байгууллага

болон үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн Хүүхдийн Зөвлөлийн нь нийт 73 гишүүнтэй байхаас нээлттэй гишүүнчлэл шалгаруулах бүртгэлийг тус сард цахим хуудсаар зарлаж Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 5 дугаар сургуулийн 40 хүүхдийг сонгон шалгаруулж бүртгэлээ. Хүүхдийн зөвлөл нь хүүхдийн эрх, боловсрол, эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, аюулгүй байдал, соёл урлаг, спорт, хүмүүнлэг, цахим хөгжил, хувь хүний хөгжлийн хороотой бөгөөд хүүхэд өөрийн хүсэл сонирхлынхоо дагуу харьяалагдана. Аймгийн Хүүхдийн Зөвлөлийн гишүүн болсноор хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх үйл ажиллагаанд үе тэнгийнхнээ төлөөлөн, дуу хоолой болон оролцохын зэрэгцээ чадварлаг баг хамт олон, эерэг хүрээллийг бий болгон хамтдаа суралцаж, өсөж дэвших боломж нээгдэх давуу талтай.

ЗГХА ГБХЗХГ-аас Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУХЭЗБ)-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй ХЭХЗХ-ны удирдлага, нарийн бичиг нарыг чадавхжуулах сургалтад тус байгууллагаас 2 албан хаагч хамрагдаж сургалтаар хорооны хурлын бэлтгэл хангах, хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хурал зохион байгуулах зэрэг зохион байгуулалтын арга зүй, хяналтад байгаа хүүхдийн сэтгэл зүйг танин мэдэх, хэрэгцээг тодорхойлж төлөвлөлт, хэрэгжилтийг үр дүнд хүргэх зэрэг үзүүлэх үйлчилгээг чанаржуулах арга зүйг тус тус олголоо. Мөн сургалтын явцад “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны кейс менежментийг сайжруулах” менторын хөтөлбөрт Дорноговь аймаг шалгарлаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны шуурхай хуралдааныг зарлан хуралдуулж, хохирогч 3 хүүхэд, сургууль завсардсан 3 хүүхдийн асуудлыг хэлэлцлээ. Эдгээрийн үр дүнд “Хүүхэд эрхэм хэрэглэгч 2023” нэгдсэн арга хэмжээг олон салбарын хамтын ажиллагааны үр дүнд зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулж байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 25 дуудлага мэдээллийг хүлээн авснаас тайлант сард Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Иххэт сумдын 13 дуудлага мэдээллийг хүлээн авч холбогдох хамтарсан багт шилжүүлж, хяналт тавьж ажилласан. Өмнөх оны мөн үеэс 4 дуудлага мэдээлэл буюу 30,8 хувиар өссөн. Дуудлага мэдээллийн төрлөөр нь авч үзвэл бие махбодийн хүчирхийлэл 3, боловсролын орчин дахь сурган хүмүүжүүлэгчийн зөрчил 2, үл хайхрах хүчирхийлэл 5, сэтгэл санааны хүчирхийлэл 2, бэлгийн хүчирхийллийн 1 дуудлага мэдээллийг ирүүлсэн байна. Дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 7 буюу 53,8 хувь.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу 18 насанд хүрээгүй 4 хүний оролцсон гэмт хэргийн хохирогч, зөрчил гаргагч хэрэгт тус байгууллагаас Цагдаагийн газарт хууль ёсны төлөөлөгчийг томилон хүүхдийн эрхийг хангаж ажиллалаа.

Сайншанд, Замын-Үүд сумдын түр хамгаалах байраар нийт 3 хүүхдийг хүлээн авч 1-26 хоногийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна. Эдгээрээс бэлгийн хүчирхийллийн хохирогч Н-ийн хууль ёсны төлөөлөгчийг цагдаа, прокурорын холбогдох албан хаагчидтай уулзуулж хэргийн бүртгэлийн явц дахь хүүхэд хамгааллыг хангаж ажилласан. Мөн Замын-Үүд түр хамгаалах байранд

эрсдэлт бүлгийн айл өрхийн 13, 19 настай охидыг хүлээн авч өдрөөр үйлчилгээ үзүүлж усанд оруулж, хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулсан. Цагдаагийн байгууллагад холбон зуучилсан. 13 настай Ж овогтой М-д хавар намрын куртик, подволк, өмд, пүүз авч өгч хувцасласан. Мөн гэр бүлд нь түр хамгаалах байрны нөөцөөс гурил, гоймон, ахуйн хэрэглээний эд зүйлс өгч хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй байгаа 2 хүүхдэд сургалтын төлөвлөгөөний дагуу зан үйл засах өөртөө итгэх итгэл, харилцаа хандлага, ирээдүйн зорилго тодорхойлох ярилцлага өрнүүлж санаа бодлын сонсож, зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Мөн Айраг сумын сургуулийн дотуур байранд үүсээд байгаа нөхцөл байдлыг тодруулж, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн суманд ажиллаж нөхцөл байдлыг тодруулж ажиллах явцад дотуур байранд үе тэнгийн дарамт ажиглагдсан тул цаашид энэ чиглэлийн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлийг Айраг сумын ЗДТГ-ын дарга, ЕБС-ын дотуур байрны багшид өгч ажиллалаа.

Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр:

“Нэг Тэрбумаараа Тэмцье” олон улсын хөдөлгөөний 10 жилийн ой энэ онд тохиосон бөгөөд уг хөдөлгөөн дэлхийн 150 гаруй улсад зохион байгуулагддаг. Тус хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд жил бүрийн 03 дугаар сарын 08-ны хийдэг уламжлалтай. Энэ жил “Эмэгтэйчүүдийн эрх чөлөөний төлөө тэмцье” уриатайгаар зохион байгуулагдсан. Тус арга арга хэмжээг Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн багш, сурагчид болон иргэд олон нийтийн оролцоотойгоор зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь жендерт суурилсан хүчирхийллийн даван туулагчид, охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоохыг уриалах, хохирогч, даван туулагчдын дуу хоолойг бусдад хүргэх чухал ач холбогдолтой юм.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн төгсөх ангийн сурагчдаас “Мэргэжил сонголт, мэргэжлээ хэрхэн сонгох вэ? Таны сонгосон мэргэжил амьдрал дээр” сэдвийн хүрээнд асуумж, судалгаа авч дүгнэхэд нийт сурагчийн 20 гаруй хувь нь мэргэжлээ сонгоогүй, 20 хувь нь сонгосон мэргэжилдээ эргэлзсэн, итгэлгүй байсан. Уг судалгааны дүгнэлтийг сургуулийн нийгмийн ажилтанд хүргүүлж холбогдох байгууллагаас энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг зөвлөлөө.

Дорноговь аймгийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Байгууллагуудын эрүүл мэндийн ажилтан бэлтгэх” сургалтад хамрагдаж байгууллагын ажилчид албан хаагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдлэг ойлголтыг олж ажлаа. “МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН” МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯНЫ ХҮРЭЭНД ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн төгсөх ангийн 70 гаруй сурагчдаас асуумж авч нэгтгэсний үндсэн дээр дараах 5 мэргэжлийг сонгосон. Үүнд: Эмнэлэг, Цагдаа, Банк санхүү, Төрийн алба, Татварын гэсэн чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагатай хамтран

ажиллахаар болж мэргэжлийн чиг баримжааны практик мэдлэгийг олгосон. Энэхүү арга хэмжээний хүрээнд Дорноговь аймгийн Цагдаагийн газар нийт 45 гаруй сурагч хамрагдаж мэргэжлийнхээ чиг баримжааны практик мэдлэгийг олж авлаа.

Гэр бүл, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр:

Даланжаргалан сумын Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 281 дүгээр байгууламжийн 45 албан хаагчид “Гэр бүлийн боловсрол”, “Хосын харилцаа”, “Хүүхэд хамгаалал-хүмүүжлийн эерэг арга сэдвийн хүрээнд сургалт арга хэмжээг зохион байгуулж, гэр бүл төлөвлөлт, хууль ёсны гэрлэлтийн ач холбогдол, асран хамгаалагчийн хүүхдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, хүүхэд хамгааллын талаар мэдлэг олгосон. Мөн арга хэмжээний үеэр "САЙН УУ ХАЙРТ МИНЬ" сэтгэл зүйн 6 төрлийн картаар хосууд хүсэл мөрөөдлөө бие биедээ хуваалцаж, бие биеийнхээ амьдралыг танин мэдэж, гэр бүлийн эерэг харилцааг үүсгэх тестийг ажилласан. Нийт оролцогчийн сэтгэл ханамж өндөр, баярлаж талархсанаа илэрхийлсэн нь арга хэмжээ үр дүнтэй болсныг харуулж байна. Арга хэмжээний төгсгөлд хоёр байгууллагын албан хаагчид оролцсон "OPEN MIC" чөлөөт арга хэмжээг зохион байгууллаа.

Хамтарсан багийн дарга, нарийн бичиг нарыг чадавхжуулах, хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд үзүүлж буй хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг чанаржуулах зорилгоор 2 удаагийн “кейс хэлэлцүүлэг”-ийг цахим хэлбэрээр зохион байгуулж сумдын Засаг дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг хамрууллаа. Тус хэлэлцүүлгээр хүүхдийн элчийг үйл ажиллагааг эрчимжүүлэх, ХТУ-108 дуудлага мэдээллийн мөрөөр авч хэрэгжүүлж байгаа хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг эрчимжүүлэх, НАМС программыг жигдрүүлэх, шуурхай тусламжийн болон гэр бүлийн орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхэд санхүүжилтийг олгох нь зэрэг арга зүйг олголоо.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хөтлөн явуулах чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй “Чанарын менежментийн тогтолцоо, стандартын дотоод аудитор бэлтгэх” сургалтад 1 албан хаагч, Аймгийн ҮЭ-ээс зохион байгуулсан “Хөдөлмөрийн харилцааны цалин хөлсний бүртгэлийн бодлого” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг тус тус хамруулж ажлын байранд мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Мөн Хүүхэд хөгжлийн төвийн дэргэдэх шатрын дугуйлангийн багш Г.Чулуунбаатар нь төрийн дээд одон медалиар шагнагдсан тул хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд тус байгууллагад 38 албан бичиг ирснээс хариутай 13, хариугүй 25 албан бичиг байна. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн болон огт шийдвэрлээгүй албан бичиг байхгүй болно.

### **БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Сургууль, цэцэрлэгийн 2022 оны төсвийн орлого зарлага гүйцэтгэл, нийт хөрөнгийн тайлан БДБ-16, БДБ-16.1, Б-СӨБ-8, Б-СӨБ-9 мэдээг боловсролын мэдээллийн системд хянан нэгтгэж байна.

“Харилцан хүндэтгэе” сарын аян үндэсний хэмжээнд “НАДААС, ТАНААС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ” уриатайгаар явагдана. Жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, жендер, жендерийн хэвшмэл ойлголт, жендерт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, сайн туршлага, санаачилгыг түгээн дэлгэрүүлэх зорилготой энэхүү аяныг гуравдугаар сарын 1-нээс дөрөвдүгээр сарын 1-ний хооронд орон даяар зохион байгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас манайд хандаж, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор "Луужин" ХХК-ний Luujin аппликейшныг ашиглан "Хүүхдийн аюулгүй тээвэрлэлт ба хамгаалалтын суудал" цахим судалгааг 2023.03.01-2023.03.15-ны хооронд авах ажлыг зохион байгуулж байна

Политехник коллежийн хаврын элсэлтийн ТМБ-8-8.3 мэдээг хянан хугацаанд нь явуулав.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл үргэлжилж 2023 онд төгсөх 426, өмнөх оны 16 шалгуулагч нийт 442 хүн бүртгүүлсэн

“Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний суурь мэдээллийн сан бүрдүүлэх” сургалтыг БҮТөвөөс 21 аймаг, 9 дүүргийн мэргэжилтэн, цэцэрлэгийн эрхлэгч нарт зориулсан цахим уулзалтад оролцсон.

БЕГ-аас ЕБС-ийн хичээлүүдэд хэрэглэгддэг программ хангамжийг сайжруулах ажлыг зохион байгуулах үүднээс 22 сургуулиас программ хангамжийн судалгааг авч нэгтгэлийг хүргүүлэв.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд БЕГ-аас 21 аймаг, 9 дүүргийн ЕБС, СӨБ-ын эмч нарт сүрьеэ өвчний талаарх онолын мэдлэг олгох, сургуулийн орчинд сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг эрт оношлох болон оношлогдсон тохиолдолд ялгаварлан гадуурхалтад өртөхөөс сэргийлэх зорилгоор цахим сургалт зохион байгуулсан.

“Шүүр” ажллагааны хүрээнд АШУҮИС-ийн Дорноговь аймаг дах салбар АУС, Политехник коллежийн судалгааг авсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллага, гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлж, БҮТ-д цахимаар хүргүүлээ.

Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багш нарт БШУЯ, БЕГ-аас “Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй” -III шатны сургалтыг СӨБ-ын бүлгийн багш, хөгжмийн багш, биеийн тамирын багш нарт 2023.03.17-2023.03.31-нийг хүртэл цахимаар платформ болон вебинар хосолсон сургалт зохион байгуулагдлаа.

Дорноговь аймгийн ЕБС-иудын хүүхдийн сэтгэл зүйн онцлог, эрсдэлийг тодорхойлох судалгааг авч байна.

СӨБ-ын Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг цэцэрлэг бүр багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дата дээр үндэслэн хэрэгцээгээ тодорхойлж багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг аймгийн хэмжээнд нэгтгэн Боловсролын ерөнхий газарт заасан хугацаанд хүргүүлсэн.

“Хүүхдийн хөгжлийн үнэлгээний аргагүй” 3 дахь шатны цахим сургалтын бүртгэлийг СӨБ-ын багш нарын дунд цахимаар явуулсан.

Сайншандын 1, 2, 3, 5-р сургуулиуд дээр “Сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зөвлөн туслахаар ажиллав

2023-2024 оны хичээлийн сурах бичгийн захиалгыг нэгтгэж БЕГ-т хүргэв.

Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын танхимын сургалтыг Сайншанд сумын ЕБ-ын лаборатори 2-р сургууль дээр 2023.03.30, 31 өдрүүдэд зохион байгуулагдлаа. БЕГ-ын сургагч багш нар сургалтыг зохион байгуулж, сургалтад 14 судлагдахууны 126 багш хамрагдлаа.

МБСБ-ын чанарын үнэлгээний шалгалтыг 2023.03.27-30-ны өдрүүдэд Политехник коллежид зохион байгууллаа. Чанарын үнэлгээнд Автомашины засварчин, Барилгын засал чимэглэлч, Барилгын цахилгаанчин, Тогооч, Гагнуурчин мэргэжлийн ангийн 2-р курсын 85 суралцагч, 8 багш, удирдлага, 15 төгсөгч, 8 ажил олгогч, 3 эцэг, эх хамрагдлаа.

БЕГ, Удирдлагын академиас зохион байгуулж байгаа “Боловсролын менежмент, технологи, манлайлал”-ын сургалтад 5 мэргэжилтэн хамрагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол олгох 42, ерөнхий боловсрол олгох 21 объектын эрсдэлийн өөрийн үнэлгээг хийлгэсэн.

Монгол орон даяар "Музейн нээлттэй өдрүүд" 2023.03.01-05 өдрүүдэд үнэ төлбөргүй үйлчлэх тул Сайншандын Музей сургалт, судалгааны төвийг эдгээр өдрүүдэд тайлбартайгаар багш нар үзэж байна

“Чанарын форум” уулзалтад ТЗ болон ТҮ-ний алба хаагчид хамрагдсан.

Бага анги, дизайн технологи, физикийн судлагдахуунуудаар анги хамт олны олимпиадыг зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын 10 сургуулийн 12-р ангийн сурагчдаас физикийн судлагдахуунаар ЭЕШ-ын урьдчилсан сорилго авч дүн мэдээг сургуулиудад хүргэсэн.

ЭЕШ-д бэлтгэх сорилгыг хуваарийн дагуу авав

“Залуучуудын оролцоо-Хотын хөгжилд 2023” Сайншанд сумын залуучуудын чуулга уулзалтад 2 мэргэжилтэн хамрагдаж үзэл бодлоо илэрхийлж, туршлага солилцлоо.

Сургууль цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулах, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг ахиулах зорилгоор Сайншанд сумын ЕБ-ын 1,2,3,5-р сургуулийн бага ангийн багш нар болон 13н цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш нар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Нийгмийн Даатгалын хууль тогтоомжийн шинэчлэлийн хэлэлцүүлэгт ЕБС-5, СӨБ-5 багш ажилтан, БШУГ 5 албан хаагч оролцож санал бодлоо илрхийллээ

Орон нутгийн төрийн албан хаагчдад “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хүний хөгжил” сургалтыг зохион байгуулсан

Алсын хараа 2050 сургагч багш бэлтгэх сургалтад байгууллагын дарга 3 мэргэжилтэн оролцож амжилттай суралцлаа. Мөн 40 хүнийг урьж сургалтад хамруулахаар мэдээллийг илгээгээд байна.

Сайншанд 1, 2, 3, 5 дугаар сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын санал хүсэлтийг авч, тухайн сургуулиудын бага анги хаицуан ажилладаг сургалтын менежерүүдтэй уулзаж, цаашид хэрхэн ажиллах талаар ярилцаж, зөвлөлөө.

3 сарын 22-26-ны хооронд “Мэдээллийн цаг-444” үйл ажиллагааг 18 сургууль зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчидтай уулзалт зохион байгуулан хийсэн ажил, үйл ажиллагаагаа танилцуулж, мэдээ мэдээллээ олон нийтэд сурталчилсан.

Бага ангийн сурагчдын унших чадварын судлагааг авч нэгтгэн сургуулиудад хүргэсэн. Унших чадварын судалгаанд анализ хийхэд шууд уншдаг сурагчид нийт сурагчдын 66,6%, уншиж чаддаггүй хүүхэд 1,4%-ийг эзэлж байгаа нь өмнөх судалгаанаас шууд уншиж чаддаг сурагчдын эзлэх хувь 9,8%-иар ихэсэж, уншиж чаддаггүй хүүхдийн эзлэх хувь 2%-иар буурсан үзүүлэлттэй байлаа.

“Равжаа 220” ойн хүрээнд бага анийн сурагчдын дунд зохион байгуулсан монгол хэл, математик хичээлийн Анги нийтийн олимпиадын 3-ын давааны дүнг нэгтгэн анализ хийхэд математик 51.7%, монгол хэл 48.7%-ийн гүйцэтгэлтэй шалгагдлаа.

Бага ангийн Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй багш нарын тоон судалгааг гаргаж, сургуулиудад хүргэн цаашид хэрхэн ажиллах чиглэл зөвлөмж өгсөн. Судалгаагаар 17 сургуульд 53 тусгай хэрэгцээт суралцагч суралцаж байгаа бөгөөд 9 сургуулийн 31 багш нэмэгдэл урамшуулал авч байна.

ЭМГ-аас зохион байгуулсан “Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх” сургалтад 1 албан хаагч хамрагдсан. “Хөдөөгийн сэргэлт” аяны хүрээнд “Боловсролын чанар, хүртээмж” брошюр бэлтгэн 100 хувь хэвлэж, АЗДТГ-т хүргэв.

“Эрүүл аж төрөхүй” эрүүл мэндийн хоёрдугаар олимпиадын удирдамжийг эцэслэн батлуулж сургуулиудад цахимаар хүргүүлсэн.

Байгууллагын 8 албан хаагч нийтийн эзэмшлийн талбай болох Чандамань-Илчийн арын жалга, жалганы ойролцоо хуваарьт талбайн хог хаягдлыг цэвэрлэж 500кг хог овоолж багийн ажлын албанд хүлээлгэн өгсөн.

БҮТ-өөс Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллага, гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх талаарх цахим сургалтад хамрагдсан

БЕГ-аас зохион байгуулсан “ЕБС-ийн сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль эрхзүйн баримт бичиг”-ийг танилцуулах, салбар

хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан.

## **ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**

### ***Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:***

- 2023 оны 03 дугаар сарын орлогын төлөвлөгөө 23.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс орон нутгийн төсөвт 10.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.
- Шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад сар бүрийн 8-ны дотор төсөв хөрөнгөтэй холбоотой 28 захирамж хугацаандаа байршуулсан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтад 500,0 сая, орон нутгийн байгууллагад 760,0 сая тэрбум төгрөг, сумдад дэмжлэг 141,0 сая төгрөг, төрийн өмчийн байгууллагуудын тогтмол зардалд 860,4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Төрийн аудитад хүргүүлсэн.
- Улсын болон орон нутгийн нярав, нягтлан бодогчдыг чадавхжуулах, Төрийн сангийн удирдлагын цахим системийн нэвтрэлтийг CTSYSTEM 6.0 онлайн программтай холбох, орон нутгийн өмчийн тайлан мэдээг цахим системээр нэгтгүүлэх сургалтыг 3 дугаар сарын 20, 21-ний өдөр зохион байгуулсан.
- “Иргэдийн төсөв 2023” эцэслэн аймгийн ЗДТГ-ын сайтад байршуулж, олон нийтэд мэдээлсэн.
- Нэмэлт санхүүжилтийн 29 байгууллагын хүсэлтийг үндэслэн 278 сая төгрөгийн хүсэлтийг үндэслэн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд 3 байгууллагын нягтлан бодогч, 1 байгууллагын дарга солигдсонтой холбогдуулан холбогдох эрхийг баталгаажуулсан. Мөн гар утасны төхөөрөмж сольсон, нэг удаагийн нууц үг баталгаажихгүй төлөвт шилжсэн 10 хэрэглэгчийн нууц үгийг дахин сэргээж төлбөр тооцоо хэвийн дамжих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.
- Айраг сумын Эрүүл мэндийн төвийн дансыг нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлэн бүртгэлийн дансыг нээлгэсэн.
- 4 аж ахуйн нэгж байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тухайн байгууллагын албан хүсэлтийг үндэслэн засварласан. 2023 онд шинээр байгуулагдсан 7 аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн И-Баланс системд бүртгэн нэвтрэх нэр, нууц үгийг өгөн заавар, зөвлөгөө өгч ажилласан.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2023 оны 03 сарын 1-31-ний хооронд нийт 1413 гүйлгээний 6477.3 сая төгрөгийн төлбөр тооцоог Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд бүртгэснийг төлбөрийн



хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шаардлагатай тохиолдолд анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

### **Статистикийн хэлтэс:**

#### **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 2 дүгээр сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан. Орон нутгийн телевизэд 2023 оны 02-р сарын танилцуулгаар мэргэжилтэн Б.Энхцэцэг мэдээлэл хийв.
- Гол нэр төрлийн 12 бараа бүтээгдэхүүний үнэ болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн Даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, программд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулав.
- Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдын мэргэжилтнүүд 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг программд шивж ҮСХ-нд дамжуулав.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-ЗГ-1, А-ЗБ-1/, худалдааны салбарын сарын /ХУ-1/ мэдээ, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, худалдааны салбарын /ХСҮ/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж дамжуулсан.
- Үйлчилгээний салбарын үнийн 2023 оны 1-р улирлын 16 нэгж мэдээг аж ахуйн нэгжээс цуглуулан авч, ҮСХ-нд дамжуулав.
- ААНБ-ын 2022 оны жилийн эцсийн 363 нэгж мэдээг мэдээлэгчдээс цуглуулан боловсруулалт хийж, алдаагүй мэдээг хугацаанд нь дамжуулав. Мөн 2022 оны жилийн эцсийн мэдээний худалдаа, барилга, сүм хийд, тээвэр, холбоо, зочид буудал, зоогийн газар, мэргэжлийн шинжлэх ухаан, удирдлагын дэмжлэг үзүүлэх үйлчилгээ зэрэг салбарын тодруулгыг хийж, тайлбар хариуг ҮСХ-нд хүргүүлэв.
- “Цаг ашиглалтын судалгаа”-ны 3-р сарын хүрээнд аймгийн төв Сайншанд сум сонгогдсон бөгөөд мэдээлэл цуглуулагчаар Д.Мөнхболор ажиллаж байна.
- Өрхийн нийгэм, эдийн засаг, Ардчилсан засаглал судалгаанд 3-р сард судлаач Б.Мөнх-Эрдэнэ, А.Дамчой, нар ажиллаж, Дэлгэрэх, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын өрхөөс мэдээллийг цуглуулж байна. 2023 оны 02 сарын Өрхийн нийгэм, эдийн засаг, Ардчилсан засаглал судалгааны хяналтын ажлаар мэргэжилтэн Н.Түвшинбаатар Замын-үүд сумын 6 өрхөд хүрч ажиллав.
- Худалдааны цэгийн судалгааны мэдээллийг 14 сумдаас цуглуулан нэгтгэж, ҮСХ-нд дамжуулав.

- Чандмана илч ОНӨҮГ-ын өглөөний мэдээллийн цагаар 2023 оны 03 сарын 28-ны өдөр мэргэжилтэн А.Амарзаяа, Н.Түвшинбаатар нар “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан-2022”, хэлтсийн веб сайтын талаар мэдээлэл хийсэн.

### **Татварын хэлтэс:**

#### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Улс ба орон нутгийн төсөвт 4720,5 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 1845 татварын тайлан, 577 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан.
- 3-р сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 670, өрөөгөөр 264 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөөг өгсөн.
- Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 18001288 дугаарын утсаар 1621 татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлсэн. Татвар төлөгчдөөс 1800-1288-д ирүүлсэн 93 гомдлыг хуваарилж, 128 гомдлыг шийдвэрлэж баталгаажуулсан.
- Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүссэн 15 хуулийн этгээдийн мэдээллийг ТУНС-д бүртгэж, НӨАТ суутган төлөгчөөр 10 хуулийн этгээдийг бүртгэсэн байна.
- Дорноговь татварын хэлтэс цахим хуудсаар давхардсан тоогоор 16500 мэдээ мэдээллийг 96600 татвар төлөгчдөд түгээн шинээр 67 харилцагч нэгдсэн.
- Газар шилжилт хийж байгаатай холбогдуулан газрын төлбөрөө төлж барагдуулсанд хяналт тавих 46 татвар төлөгч газар эзэмших эрх шилжүүлж 1,017,047,200 төгрөгийн төлбөрөө бүрэн төлж барагдуулсан.
- Татварын ерөнхий газраас зохион байгуулсан Хураагч, ТУБ-ын чиглүүлэх сургалтад 6 албан хаагч хамрагдаж улсын байцаагчийн эрх авсан.
- 2023.03.15-16, 27 өдрүүдэд Хэлтсийн даргын удирдамжийн дагуу байцаагч нар Сайншанд сумын Шинэ эргэл, Загийн говь, Шинэ зуун, Наран худалдааны төв, 4, 7, 8-р багт байрлах авто сэлбэг, авто засварын үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн төлбөрийн баримтад хяналт шалгалтыг хийж, мөн иргэдийн тайлангийн ирцийг хангах, иргэний үнэмлэхийн QR тайлан илгээх талаар заавар зөвлөгөө өгөх, хуулийн хугацаандаа тайлангаа илгээсэн болон хуулийн хугацаандаа тайлан илгээгүй татвар төлөгчдөд эрсдэлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөн, урьд оны дутуу төлөлт 36,893.97 төгрөг болон тайлант оны урьдчилгаа 2,444,231.5 төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажилласан. Мөн Замын-үүд, Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Улаанбадрах сумдын байцаагч нар Хэлтсийн даргын удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж мэргэжил аргазүйн зөвлөгөөг өгч урьд оны дутуу төлөлт болон тайлант оны урьдчилгаа 1,373,067.34 төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажилласан.

- 3 байгууллагын 450,990,492.79 төгрөгийн зөрчилд, 15,577,797.00 төгрөгийн нөхөн татвар, 7,482,154.00 төгрөгийн алданги, 10,369,470.00 төгрөгийн торгууль ногдуулсан.

#### **Орон нутгийн өмчийн газар :**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц**

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор 101 төсөл, арга хэмжээний 51,7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс 40 төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг Аймгийн Засаг даргын захирамжаар шилжүүлсэн.
- 03 дугаар сарын байдлаар 17 тендерийг цахимаар зарласан. Мөн 6 ажлын үр дүнг нийтэлж 1 ажлын гэрээ байгуулагдсан байна.
- 2022 оны 10/12 дугаар тогтоолоор худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэн автомашины дуудлага худалдааг зарлан Сайхандулаан сумын ланд 105 маркийн авто машиныг худалдан борлуулж, дуудлага худалдаанд оролцогч ирээгүй Замын-Үүд сумын НААҮ газрын авто машины дуудлага худалдааг 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулахаар олон нийтэд зарласан.
- 5 байгууллагын 46 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж хүргүүлээд байна.
- Санхүүгийн мэдээллийг шилэн дансны хяналтын цахим системд байршуулсан.

#### **Санхүүгийн хяналт, аудитын алба:**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 04 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг, 05 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, 03 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, 06 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг, 02 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, шалгалтын дүнгийн хурлыг нийт албан хаагчдын дунд нээлттэй зохион байгуулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, урьдчилан сэргийлж ажиллах, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмж бүхий шалгалтын тэмдэглэлийг 2 дугаар цэцэрлэгт 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 58, 3 дугаар цэцэрлэгт 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 59, 6 дугаар цэцэрлэгт 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 60 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн.
- Албаны даргын түр орлон гүйцэтгэгчийн 07 тоот удирдамжаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021, 2022 онуудын санхүү аж ахуй болон бусад үйл ажиллагаанд сэдэвчилсэн хяналт шалгалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын 01 тоот нэгдсэн удирдамж, Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 08 тоот удирдамжийн дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 09 тоот удирдамжийн дагуу Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар, 10 тоот удирдамжийн дагуу Байгаль орчин аялал

жуулчлалын газар, 11 тоот удирдамжийн Хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг төсөвт байгууллагуудын 2021-2022 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

- Энэ сард энэ оны актын төлбөрийн үлдэгдлээс 5811,2 мянган төгрөгийг барагдуулж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.
- 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс сумдын төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт зориулан зохион байгуулсан сургалтын үеэр “Хяналт шалгалтаар зонхилон илэрч буй зөрчлүүд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр мэдээлэл хийсэн.
- Байгууллагын ажлын байрны сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 56 тоот албан бичгээр хүргүүлсэн.

#### **ТАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС:**

- “Дорноговь аймгийн Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион “Үйлдвэрлэгч-Ажил олгогч малчин” уриан дор зохион байгуулж, 14 сумын 350 гаруй малчдын төлөөлөл оролцсноос 30 гаруй хувь нь эмэгтэй малчдын төлөөлөл оролцсон. Зөвлөгөөнд Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн мах судлалын лабораторийн эрхлэгч Д.Бямбасайхан “Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний эдийн засгийн тооцоолол”, Монголын Үйлдвэрлэл Технологийн Паркуудын холбооны төлөөлөл, судалгаа хөгжил хариуцсан захирал Б.Артагбат “Хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн өртгийн сүлжээ”, “Солид партнерс групп” ХХК-ийн захирал Б.Цэнд-Аюуш “Монгол тэмээ-Дорноговь” төслийн танилцуулга, малчдын оролцоо, НҮБ-ын ХХААБ-ын төслийн зохицуулагч Б.Энхтөр “Малын эмийн зохистой хэрэглээ, анхаарах асуудал”, “Модель ферм” ХХК-ийн тосны үйлдвэрийн захирал Т.Баатар “Хоёрдогч түүхий эд болох малын гаралтай өөх тосыг орчин үеийн технологиор цэвэршүүлж, хүнс, гоо сайхны хэрэгцээнд ашиглах нь”, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн удирдагч Н.Оюунтуяа “Малын тэжээлийн ургамал тариалсан туршлагаас”, “Бийт Монгол” ХХК-ийн захирал О.Даваасүрэн “Замын-Үүд суманд байрлах “Мал эрүүлжүүлэн тусгаарлах, хорио цээрийн бүс”-ийн үйл ажиллагаа, давуу тал, боломжууд”, Өвөрхангай аймгийн “Өв эко мийт” ХХК -ийн захирал О.Гансүх “Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй махны үйлдвэр, малчдын оролцоо хамтын ажиллагаа” зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгсөн. Мөн малчдын санал хүсэлт, асуулт хариултыг авч, газар дээр нь хариуг өгч ажилласан.

Мал сүргээ таван төрөлд өсгөн, малынхаа чанарыг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлсэд оруулж байгаа бодит хувь нэмрийг үнэлэн зарим малчдыг аймгийн Засаг даргын “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

-Дорноговь аймаг Засаг даргын Тамгын газар, аймгийн Тэмээчдийн холбоотой хамтран Ноён Хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жил, Дорноговь аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмыг угтан зохион байгуулж буй

нүүдэлчдийн соёл, бэлчээрийн мал аж ахуйн нэгэн төрөл болох тэмээн сүргийн тоо толгойг өсгөх, үүлдэр, ашиг шимийг сайжруулах, соёл, спорт, аялал жуулчлалаар дамжуулан олон нийтэд сурталчлах говийн бахархалт тэмээг алдаршуулах зорилгоор хийж буй “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2023” тэмээний наадмыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Тэмээний наадамд 3 насны хурдан тэмээний уралдаан, тэмээний поло тэмцээн, сайхан тэмээтэй хосын төрөл, тэмээний сүү, цагаан идээ, ноос, арьсаар хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн, шилмэл буур, ингэ шалгаруулан урамшуулсан.

-Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хамтран ажиллаж байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Шилжилт хөдөлгөөний байгууллагаас орон нутагт хамтран 2023 оны 03 дугаар сарын 19-ны өдөр 110 албан хаагчдад зохион байгуулсан.

-Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалтын бэлтгэл хангасан. Оролцогчдын нэрсийг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.

-Сумдад хоршоо байгуулах замаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг мэргэжлийн байгууллага, сумд, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулахыг ХХААГ-т чиглэл болгосон.

-Мандах сумын Засаг дарга, ИТХ-д тус суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Их түмэн хүрд” ХХК-ийн гомдол, мэдээллийг уламжилж, цаашид хуулийн хүрээнд төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах мэдэгдлийг хүргүүлсэн.

-2023 онд батлагдсан нийт 99 төсөл арга хэмжээнээс 65 төсөл арга хэмжээ буюу нийт төсөл арга хэмжээний 65,7 хувийн тендерийг цахимаар зарласан.

-Замын сангийн 1, Тоног төхөөрөмж худалдан авах 1 төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг тендер зарлахад бэлэн болгож ОНӨГ-т хүргүүлсэн.

-2022 оны Улсын болон ОНХО-н ажлуудыг Аудитаас шалгах тухай бичиг ирсэний дагуу холбогдох 3 дэлгэрэгүй судалгааг ОНӨГ, Барилга хот байгуулалтай хамтран хийж хүргүүлсэн.

-Аймагт төрийн албан хаагчдад зориулсан “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт 2 өдрийн сургалтыг 200 хүнд ЗДТГ-н хамт олонтой хамтран зохион байгууллаа.

-Сангийн яамнаас зохион байгуулсан PIMIS программын анхаарах асуудлын хүрээнд зохион байгуулсан 20 минутын онлайн сургалтад хамрагдсан.

-Улаанбадрах суманд 4 худаг гаргах төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг тендер зарлахад бэлэн болгож ОНӨГ-т хүргүүлсэн.

-2022 оны үзүүлэлтээр мал аж ахуйн салбарт амжилт үзүүлсэн Сайхандулаан, айраг, даланжаргалан сумдын алтан төлийн эздийн шагналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Батцэнгэлийн Ганзориг, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Аваагийн Амгаланзаяа, аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга Мөнхбаатарын Мөнхбат болон сумдын удирдлагууд 2023 оны 3-р сарын 23-ны өдөр Алтан төлийн эздийн шагналыг гардуулан өглөө. Мөн Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдын алтан төлийн эздийн шагналыг малчны хотонд нь аймгийн Засаг дарга Очирпүрэвийн Батжаргал, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Аваагийн Амгаланзаяа болон сумдын удирдлагууд 2023 оны 3-р сарын 25-26-ны өдөр, Алтанширээ сумын алтан төлийн эздийн шагналыг малчны хотонд нь гардууллаа.

-Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн сарын аян зохион байгуулах тухай” А/215 дугаар захирамжаар батлуулсан. Энэ захирамжийн гол ач холбогдол нь мал амьтны гоц халдварт, халдварт өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх орчны цэвэрлэгээ халдваргүйтгэл хийхэд оршиж байгаа юм.

-Аймгийн ИТХ-ын ээлжит 11 дүгээр хуралдаанаар “Дорноговь аймгийн аж үйлдвэр, хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г батлуулсан.

-Сангийн яам болон Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж байгаа “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал” төслийн хүрээнд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтэс, АХБ-ны төслийн зөвлөх баг, Дорноговь, Дундговь, Төв, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт хариуцсан 60 албан хаагчдыг хамруулан 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Мөн 2 дахь өдөр нь Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал болон Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөхүүд Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслүүдийн явцтай газар дээр нь үзэж, танилцаж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

-Сүхбаатар аймагт зохион байгуулагдаж байгаа тогооч нарын ур чадварын бүсийн уралдаанд манай аймгаас оролцох 16 хүнийг дэмжиж тус холбоонд 2000,000 төгрөгийн зардал гаргах захирамж гарсан.

-“Хүн төвтэй хөгжлийн жил”-ийн хүрээнд “Дорноговь аймгийн Мал эмнэлгийн салбарын ажилтны зөвлөгөөн-2023” зохион байгуулахад хамтран ажилласан.

-Хэлтэст өнгөрсөн энэ сард нийт 100 албан бичиг ирж, хариутай 34, бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, бусад 66 албан бичиг нь мэдээлэлд авах болон цаашид авч хэрэгжүүлэх тухай байсан.

## **ЗУРГАА: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

Аймгийн 2022 оны гүйцэтгэл, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний багц тайлан гаргаж аймгийн Засаг даргын 2023 оны 01/210 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын цахим хуудсанд 2022 оны тайлан мэдээллийг байршуулж олон нийтийг мэдээллээр хангасан.

Засгийн газрын ХШҮ-ний цахим сангаар өгөгдсөн Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 20, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 19, Ерөнхий сайдын үүрэг даалгаварын 7 заалт, арга хэмжээний 01,02 дугаар сарын байдлаар гаргаж тайлагнан баталгаажуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шуурхай үүрэг даалгавартай холбоотойгоор хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сүүлийн 3 жилийн хэрэгжилтийн 142 заалтын хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулсан.

Засгийн газрын болон Дорноговь аймгийн ХШҮ-ний цахим санд 2023 оны тайлан авах бодлогын баримт бичгийг нэгтгэн оруулж тайлангийн хуваарийг гарган холбогдох хэлтэс, байгууллагуудад хүргүүлсэн.

Шинээр батлагдан гарсан Засгийн газрын 3 тогтоол, 2 хуралдааны тэмдэглэл, аймгийн ИТХ-ын 15 тогтоолыг хүлээн авч бүртгэн хяналтад авч ажилласан.

---oOo---